

МОНГОЛ-МИНГИЙН ХУДАЛДААНЫ ХАРИЛЦАА:
Худалдааны хориг ба уулгалалт довтолгоо (1380-аад оноос 1570 он)

ПҮРЭВСҮРЭНГИЙН ДЭЛГЭРЖАРГАЛ
МУИС-ийн Түүхийн тэнхимийн профессор

Хураангуй: Хоёр улсын тухайн үеийн улс төр, төрийн гадаад харилцааны бодлогын өөрчлөлт нь Монгол Мингийн худалдааны харилцааг тодорхойлж байв. Мин улсын гадаад бодлогын өөрчлөлт нь Монгол-Мингийн худалдааны харилцаанд шууд тусгалаа олдог байсан нь Мингийн хааны ордон гадаад худалдаандаа монополь эрхтэй байсантай холбоотой юм. Монголын талаарх Мингийн гадаад бодлого хувьсан өөрчлөгдөж, Монгол улсыг шууд түрэмгийлэх бодлогоос хараат улс болгох бодлогод, улмаар харилцааг тусгаарлаж, эдийн засгийн хориг тавих бодлогод шилжсэн нь хоёр улсын худалдааны харилцаанд шууд нөлөөлсөн байдаг. Мин улс гадаад худалдааг улс төрийн дарамт шахалт үзүүлэх хэрэгсэл болгон ашиглаж, худалдааны хэмжээг хязгаарлах, зарим барааг худалдахгүй байх, хилийн худалдааг хаах зэрэг арга хэрэглэдэг байсан. Үүний эсрэг монголчууд Мингийн хил хязгаарыг уулгалан довтолж, дарамт шахалт үзүүлэх тактик баримталдаг байв. Гэвч үнэн хэрэг дээрээ, монголчуудын хилийн уулгалалт довтолгоо нь Мин улсын худалдааны хоригийн эсрэг, хилийн худалдаа нээхийг шаардсан шаардлагыг агуулдаг байсан ажээ. Монгол – Мингийн худалдааны түүхээс харахад, худалдааны хориг - уулгалалт довтолгоо нь хоорондоо салшгүй холбоотой байж, Монгол – Мингийн харилцааг тодорхойлогч зүйл болсон ажээ.

Монгол-Мингийн худалдааны харилцааг дараах үеүдэд хуваан үечлэх боломжтой юм. Үүнд,

1. *Монгол-Мингийн шууд бус худалдааны үе. (1368-1402 он).*
2. *“Ордны” болон “хилийн” худалдаа хөгжсөн үе (1403-1450 он).*
3. *Мин улсын зүгээс тавьсан худалдааны хоригийн үе (1450-иад оноос – 1570 он).*
4. *Монгол-Мингийн худалдааны харилцаа сэргэсэн үе (1571-ээс XVII зууны эхэн хүртэл).*

Энэхүү өгүүлэлд 1571 он хүртэлх Монгол-Мингийн худалдааны харилцаанд нөлөөлсөн гол хүчин зүйл, харилцааны хувьсал өөрчлөлтийг авч үзсэн болно.

Түлхүүр үг: Монгол-Мингийн худалдааны харилцаа, худалдааны хориг, элчин худалдаа, ордны худалдаа, хилийн худалдаа, адууны зах.

Keywords: Mongol-Ming Trade Relations, Trade Embargoes, Envoy Trade, Court Trade, Horse Market

УДИРТГАЛ

1368 онд Их Юань улсын хаан Тогоонтөмөр босогчдын хүчинд шахагдан Ханбалгасыг орхин Шанду руу явжээ. Тогоонтөмөр хаан Ханбалгасыг орхисноо Их Юань улсын төр Шанду дээд нийслэлд шилжин байрлаж байгаа хэрэг хэмээн үзэж, Ханбалгас дахь ноёрхлоо сэргээхийн төлөө тэмцээр байв. Энэ бодлогыг түүнийг залгамжилсан Аюушридар (1370-1378), Төгстөмөр (1378-1388) нар мөн баримталжээ. Гэтэл Мин улсыг үндэслэгч Жу Юаньжан өөрийгөө Их Юанийг залгамжлагч гэж зарлаад, Юань улсын байр суурийг эзлэх бодлого явуулав. Ингэснээр Монгол улсын их хаан, Мин улсын хуанди нарын аль аль нь Их Юань улсын залгамжлагч албан ёсны их хаан гэдгээ нотлох гэж тэмцэлдэв. Ийм нөхцөлд, Монгол, Мин хоёр улс харилцан биенээ хүлээн зөвшөөрч чадахгүй, дайсагнаж байсан цагт худалдааны харилцаа тогтвортой, тогтмол хэвийн явагдах ямар ч боломжгүй нь мэдээж юм.

Монгол-Мингийн харилцаа нь тодорхой үе шат дамжин хөгжиж төлөвшсөн үйл явц бөгөөд хоёр улсын тухай, тухайн үеийн улс төр, төрийн гадаад харилцааны бодлогын өөрчлөлт нь Монгол-Мингийн худалдааны харилцааны яг тэр агшин үеүдийг тодорхойлж байлаа. Ялангуяа, Мингийн гадаад бодлогын өөрчлөлт түүнийг дагаад хэрэгжүүлдэг худалдааны хориг тавих бодлого нь Монгол-Мингийн худалдааны харилцаанд шууд тусаж байсан юм. Ингэж худалдааны хоригийн бодлого барьж харилцах нь Мингийн хааны ордон гадаад худалдааг гартаа төвлөрүүлэн атгаж, монополь эрхээ хадгалах гэсэн төрийн бодлоготой нь салшгүй холбоотой. Нөгөө талаар Мин улсаас хараат гэдгээ хүлээн зөвшөөрч “алба” барьсны хариуд л сая худалдаа хийхийг зөвшөөрөх зарчмыг Мин улс байнга баримталж байсан юм. Харин үүнийг нь үл зөвшөөрдөг Монгол улс худалдааны хориг тавих Мингийн бодлогыг нь эсэргүүцэхдээ тус улсын хил хязгаарыг уулгалан довтолж, дарамт шахалт үзүүлэх стратеги, тактик баримталдаг байжээ. Ийм эсрэг тэсрэг бодлого баримтлах нь хоёр улсын харилцааны зөрчлийн үндэс болж байв.

Мин улсын Юнлэ хаан XV зууны эхэнд зурвасхан агшинд маш идэвхтэй гадаад бодлого явуулсан нь Монгол-Мингийн худалдааны харилцаа зарим талаар урагш ахиж, “ордны (элчин)” болон “хилийн” худалдаа гэсэн хоёр үндсэн хэлбэр төлөвших нөхцөл бүрдүүлсэн ч цэргийн агт морьдоор Мин улс дутагдаж байсан нөхцөл байдал нь яваандаа Монгол-Мингийн худалдаа хөгжихөд чухал түлхэц болсон гэдгийг онцолмоор байна.

Монгол-Мингийн худалдааны харилцааг судлахад хятад сурвалжийн мэдээ баримт маш чухал. «Мин улсын магад хууль»¹, «Мин улсын судар»²-ын холбогдох мэдээ баримтаас монгол хэлнээ орчуулж буулгасаар байгаа. Тухайлбал, Мин улсын магад хуулийн Ойрадын түүхэнд холбогдох баримтыг түүвэрлэснийг Шинжааны Ардын хэвлэлийн хороо 1982 онд нийтэлсэн. Түүнийг нь «Тод номын

¹ 明實錄. 中华书局出版, 共183册. 2016

² 明史. 中华书局出版, 1974

гэрэл төв» монголоор орчуулж, хоёр ботиор хэвлэснийг³ судалгаандаа хэрэглэсэн. Гэхдээ тус түүвэрт оруулаагүй мэдээ баримтыг бид Мин улсын магад хуулиас түүвэрлэж ашиглалаа.

МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхэлж «Мин улсын судар»-ын Уг тэмдэглэл болон Татар, Ойрад, Урианхайн бүлэг зэрэг шастираас монгол хэл рүү орчуулж гурван ботиор хэвлэсэн нь эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий орчуулга болсон⁴.

Буянхүү, Ван Сюн нар Монголын түүхэнд холбогдох Мингийн үеийн хятад сурвалжаас түүвэрлэж сонгон олон ботиор эмхэтгэснийг Өвөр Монголын их сургуулиас эрхлэн хэвлүүлсэн бөгөөд Монгол-Мингийн харилцааны түүхэнд холбогдох гол сурвалжуудыг багтаасан нэн хэрэгтэй эмхэтгэл болсон⁵. Гэхдээ хятад сурвалж өөрийн гэсэн онцлогтой. Хятадад тогтсон аливаа төр улсын зүгээс хөрш, хил залгаа улс орон, бүс нутгийг ажиглаж анхаарах нь сулрах, харилцах нь багасахад тэдний талаарх мэдээ баримтууд албан ба албан бус түүх сурвалжид нь үзэгдэх багасах эсвэл тэмдэглэгдэхээ больдог талтай. Ийм явдал Мин улсад бас тохиолдсон юм. Мин улс нь 1450-иад оноос Монгол улс руу элч илгээхээ больж, 1460-аад оноос бүрмөсөн зогсоосноор Мингийн хааны ордон Монголчуудын талаар мэдээлэл муутай болсон нь хятадын уламжлалт төрийн түүх бичлэгт нь ч гэсэн тусч, Монголын тухай мэдээ баримт эрс багасч байв.

Харин 1571 онд Алтан хантай гэрээ байгуулж, тогтмол худалдаа хийх болсноор Монгол улсын нэг хэсэг болох Баруун гурван түмний талаарх хятадын түүх бичлэгийн мэдээлэл эрс нэмэгдэж, улмаар Ваньли хааны үе гэхэд хэд хэдэн зохиол бичигдсэн юм. Эдгээрээс «Ваньли-гийн цэргийн гавьяаны тэмдэглэл», «Харь улс орны тухай бүрэн тэмдэглэл» зэрэг сурвалжид XV зууны Монголын улс төрийн байдлын талаарх тодорхой мэдээ, баримт бий. Л.Жамсран, Ваньли-ийн цэргийн гавьяаны тэмдэглэлийн «Дундад гурван хилийн Монгол ван тайж нарын намтар»-ыг орчуулж, удиртгал, тайлбар хийсэн бол Э.Чимэдцэрэн «Харь улс орны тухай бүрэн тэмдэглэл»-ийн Татарын тухай долоон бүлгийг орчуулж, удиртгал бичиж, тайлбар дагалдуулсан юм⁶.

Монгол-Мингийн харилцааны түүхэнд холбогдох албан бус хятад сурвалж олон байдаг бөгөөд ерөнхийдөө Мин улсын магад хууль зэрэг албан түүхээс нэлээд хэмжээгээр оруулсан байдаг ч зарим сонирхолтой ховор мэдээ баримтыг агуулдагараа онцлогтой. Эдгээрээс «Цагаан нохой жилийн эх адгийн ойллого», «Монголын эх адгийн ойллого», «Гурван харуулын ойллого» зэрэг бэсрэг сурвалжийн мэдээ баримтаас судлаач Д.Идэр түүвэрлэн орчуулж, хэвлэжээ⁷.

³ *Мин улсын магад хууль: Ойрадын түүхийн түүвэр*. I, II боть. Хятад хэлнээс орчуулж, тайлбар бичсэн Б.Мягмаржав, Л.Энхсаруул, Ү.Мөнхдагва. Ботгийн редактор П.Дэлгэржаргал. УБ., 2023.

⁴ *Мин улсын судар*. I, II, III боть. Хятад хэлнээс орчуулж, оршил, тайлбар бичсэн Д.Ундрах, Ц.Цэрэндорж, Ч.Содбилэг. УБ., 2018

⁵ 薄音湖, 王雄. 明代蒙古汉籍史料汇编. 内蒙古大学出版社. 2006-2015.

⁶ Цю Цюсы. *Ваньлигийн цэргийн гавьяаны тэмдэглэл. Дундад гурван хилийн Монгол ван тайж нарын намтар*. Орчуулсан Л.Жамсран. УБ., 2011; Янь Цунцзянь. *Харь улс орны тухай бүрэн тэмдэглэл*. XVI-XXII дэвтэр. Орчуулсан Э.Чимэдцэрэн. УБ., 2024

⁷ *Монголын дундад үеийн түүхэнд холбогдох хятад сурвалж бичиг*. Эрхлэн хэвлүүлсэн Д.Идэр.

Харин бид, Мингийн төрийн албан баримт ашиглаж, түүвэрлэж бичсэн XVI зууны нэгэн зохиолоос⁸ холбогдох хэдэн баримт мэдээг ашиглалаа.

Мингийн үеийн албан болон албан бус хятад сурвалжуудад Монгол-Мингийн харилцааны түүхэнд холбогдох баялаг мэдээ баримт хадгалагдаж үлдсэнийг монгол сурвалжийн мэдээлэлтэй харьцуулж судлах нь XV-XVI зууны Монгол-Мингийн худалдааны харилцааны түүхийг судлах гол арга бөгөөд олон балархай асуудлыг тодруулах боломж олгодог. Тиймээс хожуу зохиогдсон⁹ ч XV зууны сүүл үе буюу Батмөнх даян хааны үеэс үйл явдлыг илүү тодорхой мэдээлэх болсон монгол сурвалжийг дурдалгүй орхиж болохгүй.

Монгол-Мингийн худалдааны харилцааг судалсан эрдэмтдийн ажлыг заавал дурдууштай. Гэвч тэдний судалгааг гүйлгэж үзэхэд л ихэнх судлаач Мингийн хил хязгаарыг уулгалсан Монголчуудын довтолгоог булаан дээрэмдэх шинжтэй гэж нэг талаас нь харж тайлбарласаар ирсэн байдал шууд харагддаг.

Монгол-Мингийн худалдааны харилцааг өрнөдөд тусгайлж судалсан эрдэмтэн бол Моррис Россаби юм. Тэрбээр Мин улс ба Дотоод Азийн нүүдэлчдийн харилцааны асуудлаар хэдэн өгүүлэл бичсэн дотор Мин-Дотоод Азийн нүүдэлчдийн худалдааг тусгайлан авч үзсэн өгүүлэл¹⁰ нь багтана. Мин улсын арван нэгдэх Жу Хоуцун хааны Жиажин (嘉靖, jiajing, 1521-1567 он)-гийн үеийн Монгол-Мингийн харилцааг К.Т.Фишер судлаад салхин цэцэг өвчин, худалдаачид, “цагаан лянхуан” бүлгэмийнхэн хоёр улсын харилцаанд хэрхэн нөлөөлснийг харуулсан сонирхолтой өгүүлэл нийтэлжээ¹¹.

Монгол-Мингийн худалдааны харилцаагаар дагнасан Хенри Сөрүсийн судалгаа¹² заавал дурдах ёстой. Тэрбээр «Мин улсын судар», «Мин улсын магад хууль» зэрэг хятадын тулгуур сурвалжийн мэдээг өргөн дэлгэр ашиглаж, Монгол-Мингийн худалдааны харилцааны ерөнхий төлөвийг маш сайн дүрсэлсэн боловч монгол сурвалжаас зөвхөн Саган Сэцэний Эрдэнийн товчийг ашигласан нь харамсалтай санагддаг. Учир нь монгол сурвалжийн мэдээллийн чанар, хамрах хүрээ Батмөнх даян дааны үеэс хойших түүхийг өгүүлэх тал дээр үлэмж ахицтай болж ирдэг төдийгүй ховор чухаг мэдээг тэмдэглэсэн байдаг.

⁸ 王世真 (wangshizhen). 弇山堂别集 (yanshantangbieji). 臺北 (taipei). 臺灣學生書 (Taiwan xueshengshu). 1965

⁹ Лувсанданзан. *Алтан товч*. Монгол бичгээс хөрвүүлж, оршил тайлбар бичсэн Ш.Чоймаа. УБ., 2015; *Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж оршвой*. Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хийсэн Ц.Шагдарсүрэн. УБ., 2015; *Хаадын үндэсний хураангуй алтан товч*. Монгол бичгээс хөрвүүлж, оршил тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2015; Саган Сэцэн. *Эрдэнийн товч*. Сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг тайлбар хийсэн М.Баярсайхан. УБ., 2015; *Чакраварди Алтан хааны тууж*. Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хийсэн Д.Заяабаатар. УБ., 2015;

¹⁰ Rossabi. M. The Tea and Horse Trade with Inner Asia During the Ming. *Journal of Asian History*. Vol. 4, No. 2 (1970), pp. 136-168.

¹¹ Carney T. Fisher. Smallpox, Salesmen, and Sectarians: Ming-Mongol Relation in the jiajing Reign (1522-67). *Ming Studies*, 1988: 1, pp. 1-23.

¹² Serruys, H. *Trade Relations: The Horse fairs (1400-1600)*. Institute Bilge des Hautes Etudes Chinoises, 1975; Sino-Mongolian Trade During the Ming. *Journal of Asian History*, Vol. 9, № 1(1975), pp. 34-56.

Их Британийн Кембрижийн их сургуулиас эрхэлж бичсэн Хятадын түүхийн цувралын Мин улсын түүхийн ботид Дотоод Ази-Мингийн харилцааг тусгайлж бичихдээ төрөлжүүлсэн нь¹³ европын хэлээрх чухаг судалгааны нэг болж чаджээ.

Өрнөдийн эдгээр эрдэмтдийн судалгаанд Монгол-Мингийн худалдааны харилцаа нь Монголчууд байнга Мингийн хилийг уулгалан довтолдог болж тасалддаг гэж учир шалтгааныг авч үзсэн нь өрнөдийн түүх бичлэгийн хэв загвар болно.

Өрнөдийн түүх бичлэгийн энэ хандлага бас Зөвлөлт болон бусад улс орны түүх бичлэгт ч үзэгдэх ба тухайн улсуудын эрдэмтэд яг ийм үзэл баримтлалтай¹⁴ байдаг. Жишээлбэл, XIV-XVI зууны Монгол-Мингийн худалдааны харилцаагаар тусгайлан ном¹⁵ бичсэн Жан Сяньгүн гэдэг хятад эрдэмтэн Мингийн хилийг уулгалж байсан Монголчуудын довтолгоог зөвхөн булаан дээрэмдэх зорилготой байсан гэж тайлбарлажээ.

Хун-у, Юнлэ хаадын цагт Мин улс нь Монголчуудыг довтолж түрэмгийлэх бодлогоо хэрэгжүүлэхийн тулд хэдэн зуун мянгаас хоёр сая таван зуун мянган хүнтэй армийг байнгын бэлэн байдалд байлгаж, улам бэхжүүлж, унаажуулахаар дотооддоо адууны тоо толгойг нэмэх бодлого боловсруулж, умард мужууддаа тусгайлан хүн томилж адууны бэлчээр нутаг хайж сонгон, тусгай захиргаа, бүтэц байгуулах, өвс тэжээлийг нь улс даяар тариалах гэх мэтээр маш их хөрөнгө зарж байж сая 1425 он гэхэд 1.58 сая толгой адуутай болсон түүхийг Ноа Грасс судалсан¹⁶ бол Липин Ван, Гэн Тянь хоёр 1368-1570 оны хооронд Мин улсаас Солонгос, Түвэд, Дундад Ази болон Монголоос адуу худалдан авч байсан түүхийн¹⁷ талаар тодорхой өгүүлжээ.

Мин улсын цайгаар адуу худалдан авах арга, зохион байгуулалтын талаар Мингийн баруун талын хэдэн мужид байгуулсан худалдааны зах төвлөрлийн жишээ (нэг удаа, Мингийн түшмэд хагас сая жин цайгаар түм гурван мянган адуу худалдан авч байсан гэх мэт)-гээр авч үзсэн өгүүллийг А.С.Мартынов бичиж Хятадын түүхийн талаарх эмхэтгэлд хэвлүүлжээ.¹⁸

«БНМАУ-ын түүх» (1966), «Монгол улсын түүх» (2003) гэсэн хоёр бүтээлд Монгол-Мингийн харилцааг товчхон бичжээ. 1966 оны гурван ботид дурдах төдий өнгөрсөн худалдааны харилцааг 2003 онд хэвлэгдсэн Монгол улсын

¹³ Denis Twitchett and Frederick Mote, eds. *The Cambridge History of China: Ming, Part 2*. Cambridge: Cambridge University Press, 1998, pp. 221–271.

¹⁴ Покотилов Д. *История Восточныхъ Монголовъ въ периодъ династiи Минъ. Санктпетербургъ, 1893; Мин улсын үеийн зүүн Монголчуудын түүх. 1368-1634*. Орчуулсан Б.Баасансүрэн, Г.Лууван. УБ., 2021

¹⁵ 张宪功. 14-16世纪世界贸易格局中的明蒙贸易与社会控制研究, 北京: 光明日报出版社, 2023

¹⁶ Grass N. A Million Horses: Raising Government Horse in Early Ming China – *Animals and Human Society in Asia. Historical, Cultural and Ethical Perspectives*. Editors R.Kowner, G.Bar-Oz, M.Biran, M.Shahar, G.Shelach-Lavi. Palgrave Macmillan, 2021, pp. 299-328

¹⁷ Wang L., Tian G. Breaking the Containment: Horse Trade between the Ming Empire and its Northern Neighbors, 1368-1570 – *Journal of World History*. Vol. 33, No. 1. Hawai'i University Press, 2022, pp. 37-71

¹⁸ Мартынов А.С. О Некоторых особенностях торговли чаем и лошадьми в эпоху Мин – *Kumay и соседи в древности и средневековье*. Отв. ред. С.Л.Тихвинский, Л.С.Переломов. Москва, Изд-во «Наука», ГРВЛ, 1970, стр. 234-250

түүхийн гуравдугаар ботид авч үзэхдээ Монгол-Мингийн улс төрийн харилцааны хэсэгт хавсаргасан байна¹⁹. Сүүлийн жилүүдэд Монгол-Мингийн харилцааг ямар нэг хэмжээгээр судалж, үнэлэлт дүгнэлт дэвшүүлсэн бүтээл цөөнгүй хэвлэгдэн гарчээ²⁰. Тухайлбал, Ж.Урангуа «Алтан хан» бүтээлдээ түмэдийн Алтан ханаас Мин улстай тогтоосон худалдааны харилцааг дурджээ²¹.

Өрнөдийн судлаачид нүүдэлчдийг соёл иргэншил бүтээдэггүй “бүдүүлэг” гэж үздэг уламжлалт онолоо баримталж Монгол-Мингийн харилцааг тайлбарладаг нь судалгааных нь гол сул тал болдог. Судлаачид Мин улсын худалдааны хориг тавих бодлого Монгол-Мингийн харилцаанд хэрхэн нөлөөлсөнд төдийлөн анхаарал тавилгүй, харин монголчуудын “булаан дээрэмдэх” довтолгоонд илүү анхаарал хандуулсаар ирсэн ажээ. Гэвч монголчуудын хилийн уулгалалт довтолгоо нь Мин улсын худалдааны хоригийн эсрэг, хилийн худалдаа нээхийг шаардсан шаардлагыг агуулдаг байсан ажээ.

Үнэн хэрэгтээ Монголчуудын уулгалалт довтолгоо нь хамрах хүрээ их, бодит улс төрийн амьдралаас урган гарсан цараатай бодлого байж, энэ бодлогоор Монголчууд, Мин улсын худалдааны хоригийг эсэргүүцэж, улмаар цуцлуулахад чиглэсэн, нэг ёсны хилийн худалдаа нээхийг шаардсан улс төр-гадаад харилцааны цогц шаардлага агуулсан үйл ажиллагаа байсан нь харагдана. Мөн Монгол-Мингийн худалдааны “ордны” болон “хилийн” гэсэн хоёр хэлбэр хэрхэн бүрэлдэн тогтож, хувиран өөрчлөгдсөн үйл явцыг судалснаар Мин улсын худалдааны хориг тавих бодлого хоёр орны худалдааны харилцаанд хэрхэн нөлөөлснийг илрүүлэх боломжтой юм.

МИН УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ: ХУДАЛДААНЫ ХОРИГ

Монгол-Мингийн эхэн үеийн харилцаа нь, нэг талаас – *Их Юань улсыг сэргээн байгуулах* гэсэн Монголчуудын бодлого; нөгөө талаас – *Монголын их хааны өмч/мэдлийн газар нутгийг эзлэн авч, түүнийг өөрийн хараат болгох* гэсэн Мингийн бодлогоор тодорхойлогдож байсныг дахин цохож тэмдэглэе. Мин улсын хуаньди Жу Юаньжан (Хун-ү-гийн үе, 1368-1398 он) яг ийм бодлого баримталж Монголыг шууд түрэмгийлэн довтолж эзлэхээр олон удаа их цэргээр уулгалан халдаж байсан билээ.

Харин Монголчууд 1388 онд Мингийн их цэрэгт ихээр ялагдсаныхаа дараа *Их Юань улсыг сэргээн байгуулах* бодлогоосоо татгалзаж, *тусгаар улсын ёсоор Мин улстай харилцах* бодлого баримталж, хэрэгжүүлж эхэлжээ.

¹⁹ *Монгол улсын түүх (XIV зууны дунд үеэс XVII зууны эхэн)*. Гутгаар боть. УБ., 2003. т. 47-53, 76-80, 92-102.

²⁰ Энхцэцэг Д. *Монголчуудын түүх (XIV зууны II хагасаас XVII зуун)*. УБ., 2022; Ариунгуа Н. *Мин улсын үеийн хятад сурвалж бичгүүд (XIV-XVI)*. УБ., 2022; Ундрах Д. XIV – XVI зууны үеийн Монголын түүхэнд холбогдох хоёр нанхиад сурвалж. *Acta Historica*. Tomus XIX, Fasc. 5, УБ., 2018; Ундрах Д. Түмү-гийн тулалдаанд холбогдох зарим асуудлыг хятад сурвалж бичгүүдээс тодруулах нь. *Historia Mongolarum*. Tom XXIII, Fasc. 5, № 23(612) 2024; Дэлгэржаргал П. Түшмэлийн засаглал: Тайшийн хүчирхэгжилт. *Historia Mongolarum*. Tom XXII, Fasc. 3, № 22(609) 2023;

²¹ Ж.Урангуа. *Алтан хан*. УБ., 2007

Гэтэл Мин улсын зүгээс Монголчуудыг өөрийн хараат болгох бодлогоо үргэлжлүүлж баримталсан нь хоёр улсын хооронд худалдаа, эдийн засгийн зөв зохистой харилцаа тогтоход гол саад тоггор болж, хоёр улсын худалдаа зогсонги, идэвхгүй төлөвтэй олон жилийг өнгөрөхөд хүргэжээ.

Мин улс хятадын төрт улсуудын уламжлалт гадаад бодлогыг үргэлжлүүлж, хөрш улс орнуудаа Мингийн хааны хараат улсууд хэмээн доромж хандах үзлээрээ үзэж, хараат байдлыг илтгэн *элч илгээж алба өргөн барих* шаардлага тавьдаг байв. Хятадын төрийн гадаад бодлогын *алба бариулах* харилцааг өрнөдийн судлаачид нэлээд ултай судалж хятадын төрт улсууд өөрсдийгөө ертөнцийн төв “Дундад улс” хэмээн олон улсын харилцааны төвд тавьж, бусад улс орныг хараат, вассал гэж үздэг “хятад төвт бодлогыг” гадаад харилцаандаа баримталдгийг тэмдэглэсэн. Гадаад харилцааны энэхүү хятад төвт үзэл нь худалдаа арилжаанд барьдаг бодлогод нь ч нөлөөлжээ. Нэг ёсны, Мин улсын гадаад худалдаа нь, нөгөө этгээд “хараат” улс гэдгээ хүлээн зөвшөөрөхөөс нааш хэвийн явагдахгүй зарчим дээр үндэслэсэн улс төрийн бодлогод суурилжээ. Эртээс уламжилж ирсэн гадаад худалдаа-улс төрийн харилцааны энэхүү бодлогыг хятад эрдэмтэн Хоу Рэньжи “алба өргөхгүй бол худалдаа байхгүй, алба өргөвөл [худалдаа нээгдэж,] шан харамж ч ирнэ” гэж маш товч тодорхойлжээ.²²

Иймд, Мин улсын гадаад худалдааг тус улсын гадаад улс төрийн бодлогынх нь үргэлжлэл, гол хүчин зүйл нь байсан гэж үзүүштэй. Ингэж гэмээн сая худалдааны харилцааны үнэн төрх нь илэрдэг. Өөрөөр хэлбэл, Мин улстай худалдаа хийх зөвшөөрлийг олгохдоо – Мин улсын хараат улс гэдгээ хүлээн зөвшөөрч, “алба” барих шаардлагыг худалдааны харилцагч талдаа тулгадаг байсан гэсэн үг.

Мингийн цэргийн агтны хэрэгцээ Мин улсын гадаад худалдааны эхэн үеийн стратегийг тодорхойлогч гол хүчин зүйл байсан гэдгийг бид их олон удаа тэмдэглэж байгаа билээ. Тиймээс “хараат” гэдгээ хүлээн зөвшөөрч, элч илгээж “алба барьсан” улс орнууд л Мин улстай анх худалдааны харилцаа тогтоожээ²³. Тухайлбал, 1384 онд хоёр мянган агт морь илгээж²⁴ байсан Солонгосын ван 1385 онд элч илгээн Мингийн хаанд – 5,000 морь, 500 жин алт, 50,000 лан мөнгө, 50,000 боодол хөвөн давуу хүргэж “алба” барьжээ²⁵. 1385 онд Мин улсад ирсэн

²² 侯仁之(Hou Renzhi), 〈明代宣大山西三鎮馬市考〉(Mingdai xuan da shan xi san zhenma shikao), 《燕京學報》(yanjing xuebao), 期23, 1938年6月, 頁184.

²³ Солонгостой хэрхэн харилцаа тогтоосон тухай Donald N. Clark. Sino-Korean Tributary Relations under the Ming – The Cambridge History of China. Vol. VIII, Part 2. 1998, pp. 272-300-аас уншина уу. Мөн Мин улс ба Зүүн Өмнөд Азийн далай/тэнгисийн орнуудтай тогтоосон худалдааны харилцаа, мөн Жу Юаньжан, Жу Ди хаадаас Дундад Ази(Central Asia) руу чиглэсэн худалдаа-улс төрийн харилцааг энд дашрамын жишээ болгон дурдаж болох юм. Энэ тухай А.А.Бокшанин. Китай и страны южных морей в XIV-XVI вв. М., 1968, стр. 139-181; К.Ш.Хафизова. Китайская дипломатия в Центральной Азии (XIV-XIX вв.). Алматы, 1995 гэсэн зохиолоос уншина уу.

²⁴ Wang L., Tian G. Breaking the Containment: Horse Trade between the Ming Empire and its Northern Neighbors, 1368-1570 – *Journal of World History*. Vol. 33, No. 1. Hawai'i University Press, 2022, p. 67

²⁵ 明實錄 (Ming shilu). 太宗實錄 (taizu shilu). 6. т. 2584

энэ “алба” нь Мингийн 1383 онд шаардсан алба билээ.²⁶ Дараа жилүүдэд ч гэсэн 1386, 1392, 1394 онд Солонгос улсаас Мин улсад бараг хорин гурван мянган агт морь албанд “өргөн барьжээ”. Ингэж олон тооны адуугаар алба өргөж байсан ч Солонгосоос өргөдөг албаны нэгд, гурван жилд нэг удаа тавиад тооны сайн үүлдрийн азарга²⁷ өргөх ёстой байсан нь Мин улсын цэргийн агтын хэрэгцээтэй хамаатай нь мэдээж, нэг ёсны цэргийн агт морь үржүүлэх зорилгоор ийнхүү сайн үүлдрийн азарга нэхэж байжээ. XIV зууны сүүл үед ийнхүү Солонгосоос цөөнгүй тооны агт морь, үржлийн адууг алба нэрээр татаж байсан нь Мингийн цэргийн агтны хэрэгцээг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн нь мэдээж. Мин улс XIV зууны сүүлээр Монголтой тасралтгүй байлдаж байсан ба Монголд гүн цөмөрч түрэмгийлэхэд цэргийн сайн агтны хангалттай нөөцтэй байх шаардлага үнэхээр их байсан учраас л дөнгөж харилцаа тогтоосон, адуу мал багатай Солонгосоос хүртэл их хэмжээний агт морьдоор алба авч байжээ. Мингийн худалдааны эхэн үеийн бодлого нь цэргийн агтны хэрэгцээг хангахад чиглэж байсныг Мингийн түүхийн гол сурвалжийн нэг Мин улсын магад хуулиас харж болно.

Мингийн цэргийн агтны хэрэгцээг хангахад Солонгосоос гадна, Түвэд-Мингийн худалдааны гол түшиц Ганьсу, Шэньси-гийн боомтууд чухал үүрэг гүйцэтгэжээ. Түвэдүүд адуугаа ихэвчлэн цай болон бөс бараагаар арилжиж байв. Зөвхөн 1377-1384 оны хооронд зургаан удаагийн худалдаагаар 4,164 адуу Мин улсад худалдсан нь Мин улсын магад хуульд тэмдэглэгджээ. Гэхдээ энэ тоо бол бүрэн бус тоо гэдгийг анхаарах хэрэгтэй. 1385 онд Солонгосоос 5,000 агт морийг “алба” нэрээр авсан Мин улс хойтон жил нь 1386 онд 6,729 адууг Шэньси-гийн өмнөд хэсэгт байдаг боомтоор Мин улсад оруулжээ²⁸. Хойтон жил нь мөн энэ мужийн боомтоор 2,807 агт морины алба авчээ.²⁹ Мөн Мингийн томоохон түшмэл Ли Цзинлун гэгч 1398/99 онд Түвэдүүдтэй худалдаалах шинэ аргаар худалдаж авсан 13,518 агт морийг нийслэлд авчирч байжээ.³⁰ Төмөрийн улсаас³¹ гэхэд 1388 онд 300, 1389 онд 205, 1390 онд 690, 1391 онд 52, 1392 онд 84, 1394 онд 200, 1395 онд 212, 1396 онд эхлээд 240, дараа нь 1,905 адууг Мин улсад элч явуулахдаа илгээжээ.³² Мингийн эхэн үеийн цэргийн агтны хэрэгцээг дүрсэлж харуулахаар

²⁶ Donald N. Clark. Sino-Korean Tributary Relations under the Ming – *The Cambridge History of China. Vol. VIII. The Ming Dynasty, 1368-1644*, Part 2. Ed. Denis Twitchett and Frederick W. Mote. Cambridge University Press. 1998, p. 290

²⁷ ... 種馬每三年五十匹... (大明會典 (Da Ming huidian), 卷 105, ... 朝貢 1·東南夷上·朝鮮國 (Chaoxian guo))

²⁸ Serruys, H. *Trade Relations: The Horse fairs (1400-1600)*. 1975. p. 25.

²⁹ Wang L., Tian G. Breaking the Containment: Horse Trade between the Ming Empire and its Northern Neighbors, 1368-1570 – *Journal of World History*. Vol. 33, No. 1. Hawai'i University Press, 2022, p. 69

³⁰ Мартынов А.С. О Некоторых особенностях торговли чаем и лошадьми в эпоху Мин – *Китай и соседи в древности и средневековье*. Отв. ред. С.Л.Тихвинский, Л.С.Переломов. Москва, Изд-во «Наука», ГРВЛ, 1970, стр. 240

³¹ Мин улстай харилцаа тогтоохоор анх Хун-у-гийн 20-р оны дөрвөн сард (1387 оны 4-р сарын 19 – 5-р сарын 17) ирсэн Төмөрийн элч Хафиз гэгч 15 аргамаг хүлэг, 2 тэмээг харилцаа тогтоосны бэлэг болгож өгснийг Мин улсын албаны түшмэд алба өргөв гэж тэмдэглэжээ (明史 (Mingshi), 卷 332, 31864 頁).

³² 明實錄 (Ming shilu). 太宗實錄 (taizu shilu)

түүвэрлэж, толилуулсан баримтаас харахад 1384-1394 онд Солонгосоос бараг 30 мянган адуу, Түвэдээс гэхэд 1386-1392 онд бараг 27 мянган адуу, Төмөрийн улс (1388-1396 он)-аас 3,888 адуу нийтдээ 60,830 орчим агт морины “алба бариулжээ”.

Дурдсан баримт нь Дотоод Азийн улсууд болон хараат орнуудтайгаа Мин улс хэрхэн худалдааны харилцаа тогтоож, бүс нутгийн тэргүүлэгч улс гэдгээ харуулахыг зорьж байсныг, мөн Монголчуудын эсрэг хийсэн аян дайнаас болж цэргийн агтны хэрэгцээ эрс нэмэгдсэн, энэ хэрэгцээгээ Солонгос, Түвэд, Дорнод Туркестаны улсуудтай хийдэг худалдаагаар хэрхэн хангахыг оролдож байсныг гэрчилж байна. Түүнчлэн адуу худалдан авахад ихээхэн анхаарч “адууны худалдааны газар”-ыг байгуулж, цайнд улсын монополь тогтоох бодлого хэрэгжүүлсэн аж. Түвэдүүдэд гэхэд адуу худалдаалахыг зөвшөөрсөн цөөн тооны пайз тэмдэг олгож, зөвхөн Мин улсын төлөөний, ижил тэмдэгтэй түшмэлд л тэд нар адуугаа зөвхөн цайгаар сольж зарах дүрэм тогтоожээ.

Гэхдээ Мин улс анхнаасаа баруун хойд талын лалын худалдаачид, Түвэдүүд, мөн зүүн хойд талын Зүрчид болон Урианхайн гурван харуулын Монголчууд, их хааны харьяат Монголчуудтай худалдаа хийхдээ ялгавартай бодлого боловсруулж баримталсан юм.

Энэ ялгааг, Мин улстай өрсөлдөх гол хүч бол Монгол улс байсан учраас Монголчуудтай хийх худалдаанд хамгийн хатуу бодлого баримталсныг Мин улс, Дотоод Азийн бусад улс орнуудтай хийж байсан худалдаатай харьцуулахад тодорхой харагддаг.

Юнлэ хаанаас өмнө Монгол, Мингийн хооронд худалдааны харилцаа тогтоогүй байсан гэж судлаачид үздэг ч 1390 онд Монголчууд адуугаа их хэмжээний торго, торгон хувцсаар арилжсан³³ гэх ганц мэдээ Мин улсын магад хуульд байдаг. Харин лалын худалдаачид Мин улсад адуу тогтмол нийлүүлж байсан үе билээ. Тэдний авчирч зарсан адууг Мингийн түшмэд нутаг, үүлдрээр нь ялгаж тэмдэглэсний дотор “Дада морь”-ийг тодорхой хэмжээний торго, даавуугаар сольсон мэдээ бий. Магадгүй, Монголын адууг Мин улсаас ийнхүү лалын худалдаачдаар дамжуулан худалдан авах бодлого боловсруулж хэрэгжүүлсэн болов уу.

Мин улсыг үндэслэгч Жу Юаньжан 1398 онд нас барж, ач хүү нь залгамжилсан боловч дөрөв дэх хүү Жүди бослого гаргаж, 1402 онд хаан ширээг булаан авч, Юнлэ хаан (1403-1424) хэмээн өргөмжлөгдөв. Хаан ширээг хүчээр булаан авсан учраас, Мингийн хааны ордонд хүлээн зөвшөөрөгдсөн хаан болох нь түүний хувьд чухал байсан юм. Тиймээс эргэн тойрны улс орнуудад элч илгээн, Мин улсын хааны тэргүүлэх байр суурийг хүлээн зөвшөөрүүлэх идэвхтэй гадаад бодлого явуулж эхэлжээ. Гэхдээ л XIV зууны сүүлээр Мин улстай харилцаа тогтоочихсон байсан бусад улсын хувьд, урьдын ёсоор Мин улсын тэргүүлэх байр суурийг хүлээн зөвшөөрч, элч илгээн “алба” барих нь худалдаа хийх “гол нөхцөл” мөн гэсэн Мингийн төрийн бодлогыг Юнлэ хаан

³³ 明實錄 (Ming shilu). 太宗實錄 (taizu shilu)

хэвээр үргэлжлүүлжээ. Хөрш улс орнуудаа ингэж худалдаагаар шахаж, хараат болгох бодлогоо тууштай хэрэгжүүлж эхэлсэн Юнлэ хаан Монголчуудын хувьд өмнөх үеийг бодвол худалдааны арай өөр орчин бүрдүүлэх алхам хийсэн бололтой. Гэвч энэ арга хэмжээ нь Мингийн цэрэгт агт морьд дутагдаж байгаа нөхцөлийг бүрэн үгүй хийж, цэргээ байлдааны агтаар тогтмол найдвартай хангах бодлоготой уялджээ. Ингэхийн тулд Юнлэ хаан адуу худалдан авах бодлогодоо өөрчлөлт оруулж, элч илгээж, өөрөөр хэлбэл ордны худалдаа эрхлэх гарц нээж, бас хилийн худалдааны “адууны зах” нээсэн нь Монгол-Мингийн хоорондох худалдааг шинэ түвшинд гаргах зам нээсэн мэт харагдавч зэрэгцүүлж, урьдын адилаар Монгол улсыг “хувааж захирах” бодлого давхар хэрэгжүүлэхийг оролдсон нь Монголчуудын дургүйцлийг төрүүлж, мөн Мин улсад “хараат улс” гэдгээ хүлээн зөвшөөрч, элч илгээсэн хойно худалдаа хийхийг зөвшөөрье гэсэн Мингийн, Юнлэ хааны шахалт, бодлогыг Монгол улс хүлээн аваагүй тул Юнлэгийн бодлого хэрэгжиж эхлээгүй байж тасрахад хүрчээ. Тиймээс Юнлэ хаан Монгол улсын их хаан, Ойрадын ноёдтой зэрэг харилцаж хооронд нь өрсөлдүүлэх бодлогод шилжиж, хэрэгжүүлэхдээ Монгол улсын их хаан болон томоохон язгууртнуудтай зэрэг харилцаж, аль нэгд нь худалдаа хийх зөвшөөрөл олгох, нөгөө нэгд нь худалдааны хориг тавьж бас монгол ноёдыг татахын тулд цол хэргэм, тансаг эд барааг ялгавартай шагнах зэрэг эдийн засгийн аргыг шахалт үзүүлэх бодлоготойгоо хослуулж хэрэглэж эхэлжээ.

Эн тэргүүнд, Ойрадыг дэмжин Зүүн Монголын эсрэг болгож хооронд нь сөргөлдүүлэх арга бодлого хэрэгжүүлэв³⁴. Мин улсын магад хуульд тэмдэглэснээр бол 1402 оны билгийн тооллын найман сард Юнлэ хаан “сууринд суугаад Хархорум, Ойрад зэрэг газрын аймгийн толгойлогчдод элч томилж зарлиг хүргүүл(ж)”, дараа жил 1403 оны билгийн тооллын дөрвөн сард “Дахтөмөр нарыг Ойрад руу элчээр томилж, дайсны толгойлогч Махаму, Тайван, Батболд нарт зарлиг ...”³⁵ хүргэж анх удаа ойрад ноёдод “хүндэтгэл үзүүлжээ”. Гэвч тухайн бодлого ч Монголчуудыг сөхрүүлж, гавьтай амжилтанд хүргээгүй тул Юнлэ хаан Монголын эсрэг цэрэглэн халдаж түрэмгийлэх болов. Өөрийн биеэр цэрэг удирдан таван удаа аялан байлдаж, Монголчуудыг уулгалан довтолсон билээ. Нөхцөл байдал ийн эргэсэн хэдий ч Юнлэ хааны үед л үндсэндээ, Монгол-Мин улсын гадаад худалдаанд элч илгээн “бэлэг” (алба) барихтай салшгүй холбоотой “элчин худалдаа” (ордны худалдаа) болон “хилийн худалдаа” гэсэн гадаад худалдааны хоёр хэлбэр эрчимтэй хөгжиж, хойш хойшдын худалдааны харилцааны гол хэлбэр болсон юм.

³⁴ Rossabi M. *The Ming and Inner Asia – The Cambridge History of China. Vol. VIII. The Ming Dynasty, 1368-1644*, Part 2. Ed. Denis Twitchett and Frederick W.Mote. Cambridge University Press. 1998, p. 231, тэнд “For the two decades that followed his death, the Ming pursued the Yung-lo emperor’s tactic of divide and rule with similar results. At the beginning of this period, the court favored the Oirad to counteract the Eastern Mongols. The Yung-lo emperor had cemented relations with the Oyirad after the death of Mahmud by offering the title of Shun-ning wang to Mahmud’s son Toghon” гэж бий.

³⁵ 明實錄 (Ming shilu). 太宗實錄 (taizu shilu). Хун-у-гийн 35-р оны билгийн тооллын найман сарын улаагчин үхэр өдөр; Юнлэгийн тэргүүн оны дөрвөн сарын хар хулгана өдөр.

XV зууны эхний хориод жилд тун идэвхжсэн Мингийн гадаад бодлого Юнлэ хааны дараа үеэс суларч, ноёд түшмэдийн зүгээс эзэнт гүрний тэлэх бодлогод шүүмжлэлтэй хандах болж, гадаад улс орнуудын “алба” барих элчин худалдааг хязгаарлаж эхэлжээ. Мин улсын хааны ордон нь ийнхүү Юнлэ хааны цэргийн түрэмгийллээс татгалзсан хэрнээ Монголчуудыг “хувааж захирах” бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр байлаа.

Мин улс нь Тогоон, Тогтобухагийн болон Аругтай, Адайн хоёр эвслийн хоорондох тэмцлийг Монголын дотоод хэрэгт оролцох боломж болгон ашигласан нь “Монголчуудыг хувааж захирах” бодлогыг төрийн түвшинд баримталж байсны хамгийн тод илрэл юм. Гэвч уул бодлого бүрэн төгс хэрэгжих тавилангүй байв. Учир нь Тогтобуха хаан, Тогоон тайши нарын тэргүүлсэн эвсэл дотоодын тэмцэлд ялалт байгуулж, Монгол улсыг нэгтгэж, улмаар Монголчууд Мин улстай нэг л бодлогоор харилцаж эхлэв. Эсэн тайши эрх мэдэл ихсэж асан үеэс энэ бодлого үр дүнгээ өгч Монгол-Мингийн харилцаанд Монголчууд давамгайлж, Мин улсын “хувааж захирах” бодлогын сөрөг нөлөөг даван туулжээ. Шинэ нөхцөл байдлыг Мингийн хааны ордон хүлээж авахаас аргагүй байдалд хүрч, Монголын төрөөс Мин улстай худалдааны өргөн дэлгэр, тогтвортой харилцаа тогтоох бодлогыг амжилттай хэрэгжүүлэв.

Харин Жу Чинюй хааны Жинтай (jingtai, 1450-1457 он)-гийн үеэс Мин улс Монгол руу элч илгээхээ зогсоож, Монгол улсын эсрэг худалдааны хориг тавих бодлогод бүрэн шилжсэн боловч Монголчуудын хилийн уулгалалт довтолгоогоор илэрдэг Монголын талын хүчтэй шаардлага дагуу хилийн худалдааг үе үе зөвшөөрч нээж, Мин улс элч илгээх үе ч бий болжээ.

Гэхдээ бүхэлдээ энэ үеэс эхлэн хоёр улсын элчийн харилцаа, хилийн худалдаа нь тогтмол байнгын бус, цаг зуурын шинжтэй болж хувирсны гол шалтгаан нь Мин улсын худалдааны хориг тавих бодлого юм. Лунчин (longqing, 1567-1572 он)-гийн үеийн гэрээ байгуулагдах хүртэл Монгол-Мингийн харилцаа зуу гаруй жилийн турш ийм байдалтай үргэлжилж, худалдаалах явдал үндсэндээ зогсож, Мингийн худалдааны хоригийг эсэргүүцэх хамгийн үр ашигтай аргаа монголчууд хэрэглэхээс аргагүй байдалд хүрснээр хоёр орны харилцаанд илд мэс зөрүүлэн мөргөлдөх явдал давамгайлах болжээ. Өөрөөр хэлбэл, *худалдааны хориг – хилийн уулгалалт довтолгоо* гэсэн эсрэг тэсрэг бодлогын зөрчил нь Монгол-Мингийн зуугаад жилийн харилцааг тодорхойлжээ.

Лунчин (1567-1572 он)-гийн сүүлээр Түмэдийн Алтан хан ба Мин улсын хооронд байгуулсан гэрээний үр дүнд хилийн худалдаа тогтмолжиж, Мингийн хил хязгаар ч амар амгалан болов. Хорь гаруй жил үргэлжилсэн энэ харилцаа 1590-ээд онд дуусгавар болсон юм. Түмэдийн Алтан хан болон Баруун түмний жононг залгамжлагч нар тус тусдаа Мин улстай харилцах болсноор Алтан ханы бий болгосон Баруун гурван түмнээс Мин улстай харилцах нэгдмэл бодлого алдагджээ.

ОРДНЫ ХУДАЛДАА БҮЮУ ЭЛЧИН ХУДАЛДАА

Худалдааны харилцааны шинж чанараас гадна ямар хэлбэрээр Монголчууд Мин улстай худалдаалж байсныг нягталж шинжилсэн судалгаа их чухал юм. Монгол-Мингийн хоорондох “ордны” болон хилийн “адууны зах”-ын худалдааны түүхийг судлах нь Монголын худалдааны бодлого, Мингийн худалдааны бодлого яаж хэрэгжиж байсныг илүү тодорхой бодитой харж, ойлгоход туслах билээ.

Ордны худалдаа буюу элчин худалдааны мөн чанар. Хараат байдлаа хүлээн зөвшөөрч, элч илгээн “алба” (бэлэг) барьсны хариуд Мингийн хааны ордноос их хэмжээний тансаг зэрэглэлийн эд бараа, чамин зүйлийг элчээр дамжуулан тухайн орны хаад, язгууртнуудад илгээдэг байжээ. Тэдгээр улс, орноос найрсаг харилцааны илэрхийлэл болгон элчээр илгээсэн “бэлэг”-ийг харин Мингийн хааны ордон “алба” барив хэмээн тодорхойлж, түүх судартаа зориуд тэмдэглэн үлдээдэг арга, заншилтайг давтан сануулъя. Гэвч Мингийн хааны ордны хамгийн чухал шаардлага бол хараат, дагаар орсон гэж үздэг улс орнууд адуугаар “алба” барих явдал юм.

“Алба” авч, хариу “бэлэг” өгөх нь эдийн засгийн ач холбогдлоос илүүтэй улс төрийн ач холбогдолтой чухал үйлдэл байсан тул Мингийн хааны ордны хувьд Мин улсыг бүс нутгийн тэргүүлэгч улс хэмээн хүлээн зөвшөөрүүлэх явдал гадаад бодлогынх нь нэг зорилго байлаа. Ийм харилцааг найдвартай тогтоосон гэж үзсэнийхээ дараа Мингийн төрийн зүгээс хөрш орнуудын бодлогод нөлөөлж, зарим үед дотоод хэрэгт нь оролцдог байв. Тиймээс л гадаад улсын элчийн өгч байгаа “алба” (бэлэг)-ын оронд их хэмжээний тансаг эд бараагаар хариу барьдаг байсан юм. Энэ нь Мин улсын талаас, Дотоод Азийн нүүдэлчдийг өөртөө татах нэг ёсны дипломат бодлого, нөгөө талаас нүүдэлчдээс адуу худалдан авах нэг хэлбэр байлаа.

Элчин худалдаа эрхлэх зөвшөөрөл олгодог нөхцөл байдал, үндэслэл. Мингийн төрийн зүгээс Мин улсын хаанд элч илгээн “алба” барьсан гадаад улсын хаан, язгууртан нарт цол өргөмжлөн, хил хязгаарын тогтоосон боомтоор элч төлөөлөгчөө илгээж байх эрхээр хариу барьдаг. Ингэхдээ, Мин улс олгосон цолоо баталгаажуулж тамга хүргэх бөгөөд тус тамгыг дарсан бичгийг үндэслэж тухайн этгээдийн илгээсэн элчийг Мин улс хилийн боомтоор нэвтрүүлж, тогтоосон замаар нийслэл хотдоо хүрэхийг зөвшөөрдөг юм.

Мин улсын Юнлэ хаан ширээнд өргөмжлөгдмөгц Монгол улсын хаан болон Ойрадын ноёд руу элч илгээсэн нь далдуур Монголчуудыг хараат түшмэг улс болгохыг зорьсон үйлдэл болсныг өмнө өгүүлсэн билээ. Тэр явдлын дараа Ойрадын ноён Махаму 1408 оны билгийн тооллын арван сард Мин улсын элчийг дагалдуулан Нундаши (Номдаши) нарыг элчээр зарж, Мин улсад адуу өргөн барьсан тухай Мин улсын магад хуульд:

“Ойрадын Махаму нь Нундаши нарыг Иласи нарт дагалдуулан илгээж адуугаар алба бариад, тамгаа соёрхож, хэргэм өргөмжлөхийг хичээнгүйлэн гуйв. Хаан эзэн түүний

санааг сайшааж, Нундаши тэргүүтэнд хурим шагнаж, алтлаг хээтэй өвч гоёмсог торгон хувцас соёрхохыг ёслолын яаманд тушаасан”³⁶ гэж тэмдэглэжээ.

Ингэснээр 1403 оны билгийн тооллын дөрвөн сард³⁷ Мингийн хаанаас анх “үзүүлсэн хүндэтгэлд” талархсан Ойрадын язгууртнууд Мин улсад анх удаа хариу элч зарж, “алба” (бэлэг) хүргэсэн нь энэ байх. Мин улсын хааны ордноос Ойрадын элчийг гадаадын олон орноос ирсэн элч нарын хамт соёрхон шагнаж, хуримлан дайлсан тухай мөн тэмдэглэжээ.

Ордны/элчин худалдааг зохион байгуулах, худалдааны зам харгуйг тогтоох. Элчин харилцаанд тулгуурласан гадаад худалдаа нарийн зохион байгуулалттай явагддаг байжээ. Тухайлбал, Мин улсаас гадаадын “алба барих” элч, тэднийг дагалдсан худалдаачдын нэвтрэх хилийн боомт, нийслэл орох замыг нарийн зааж тогтоож өгдөг. Хэрэв тогтоосон боомт, замаар Мин улсад нэвтэрч, явахгүй бол элч нарыг хүлээн авахаас шууд татгалзана. Жишээ нь, *зүүн болон баруун Монголчуудыг Датуны боомтоор хил нэвтэрч, тогтоосон замаар нийслэл Бээжинд ирэхийг шаардаж байсан бол Урианхай монголчуудын элчийг Баясгалант хадат хаалгаар боомтод нэвтэрч, Бээжин хүрэхийг зөвшөөрчээ.*

Тэдний тогтоосон журмыг Монголчууд зөрчихөд Мин улсын эрх баригчид тун дургүйцдэг байжээ. Нэгэн удаа Урианхайн гурван харуулын элч нар бусад Монголчуудын элч нартай холилдон хамт ирсэнд Мин улсын хааны ордон ихэд дургүйцэж зэмлэжээ. Тогтсон дэг журмаас гадна зам маршрутыг ч өөрчилж аялахад бас дургүйцнэ. Жишээ нь, 1462 онд Болай тайши “элч илгээн ... алба барихаар ирж, Датуны алба барих хуучин замыг өөрчилж, Шэньси (陝西 shaanxi)-ийн Ланьсянь (蘭縣 lanxian)-аар ордог болохыг гуйсанд зөвшөөрсөн” ч хойтон жил нь “Болайн элчид зарлиг буулгаж урьдын адил Датунаар нэвтэрч, алба бариулах болов”³⁸ гэж тэмдэглэснээс үзэхэд Мин улс худалдааны зам маршрутыг тогтоохдоо баримталсан зарчмаасаа ухардаггүй байсан гэсэн үг. Сая дурдсанчлан Болай тайшийн элчид дээрхийг мэдэгдээд тэр даруй Шэньсийн худалдааны замыг хааж, урдын адил зөвхөн Датуны замаар худалдаа хийлгэхээр тогтсон гэдэг. Ингэх өөр ч учир байж мэднэ, учир юу хэмээвээс Түвэдүүд адуугаа зарахаар Шэньсид их ирдэг байсан юм.

Элч болон элчийг дагаж ирсэн худалдаачдыг байрлуулах нь. Мин улсын нийслэлд ирсэн элч нарыг тусгай газар байрлуулна. Элч нарын байрлах газарт өөр улс орны элч, худалдаачид бас байрлах учир тэднийг хоорондоо хязгаарлагдмал хүрээнд худалдаалах боломжоор давхар хангаж байжээ. Төмөрийн улсын Хератын захирагч Мирза Байсунгурын элчээр Мин улсад 1419-1421 оны хооронд ирсэн Гиас ад-Дин Накаш нь Бээжинд элч нарыг байрлуулдаг газрын талаар дэлгэрэнгүй тэмдэглэл үлдээжээ. Түүнд:

³⁶ 明實錄 (Ming shilu). 太宗實錄 (taizu shilu). Юнлэгийн 6-р оны билгийн арван сарын улаагчин хулгана өдөр.

³⁷ 明實錄 (Ming shilu). 太宗實錄 (taizu shilu). Хун-ү-гийн 35-р оны билгийн тооллын найман сарын улаагчин үхэр өдөр; Юнлэгийн тэргүүн оны дөрвөн сарын хар хулгана өдөр.

³⁸ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8471-8472 頁.

“Ханбаликт ирээд буудаллах газар (menzil-hane)-т байршуулсан. Урьдчилан бэлтгэсэн буудаллах газрын өрөө тус бүрд нь бүрэн дэвсгэртэй, зүйл бүрийн торгон олбогуудтай өргөн уртынхаа туршид цацагтай 10 ханз, сандал, нарийн оёдолтой шаахай, хүн тус бүрд нэг таваг, аяга, дийз, ширээ тавьснаас үзвэл арван хүн тутамд нэг өрөө өгсөн байна. Өдөр бүр өрөө тус бүрд суугчдад зориулан нэг хонь, нэг галуу, хоёр таваг, хүн тус бүрд хоёр батман буудай, нэг том аяга будаа, нэг ширхэг бурам, нэг дугтуй зөгийн бал, сүү, сонгино, цуу, давс, хятад тос, хоёр аяга болон нэг таваг хүнсээр ... үйлчилдэг”³⁹ хэмээн тэмдэглэжээ.

Ингэхлээр, харийн хаад, ноёдын элч нарыг байрлуулдаг тогтоосон газрууд Мингийн нийслэл, хязгаарын томоохон хот балгадад байсан нь тодорхой бөгөөд элчийг дагалдан яваа худалдаачид ч мөн тэрхүү тогтоож заасан газарт л бууж, байрладаг байжээ. Энэ нь тэдгээр худалдаачдыг хянах, хатуу хараа хяналт дор хязгаарлагдмал худалдаа хийхийг шийдвэрлэх эсвэл хориглох боломжийг Мингийн албаны хүмүүст олгож байсан хэрэг. Элч нар буудалладаг тодорхой газар худалдаа эрхлэх журам байжээ. 1423 онд гаргасан хуандийн зарлигт “Элчин болон элчийг дагаж ирсэн бусад гишүүдийн авчирсан бараанд татвар ноогдуулахгүй. Барааны үнэ ханшийг бусдын гэрчлэл, үнэлгээгээр тогтооно. [Харийн элч нар] бэлэг өргөж дууссаны дараа элч нар буусан буудлын ойролцоо өдөр бүр авчирсан бараагаа зарахыг зөвшөөрнө. Баруун газраас авчирсан торго болон нил ягаан саван, том бадамлянхуа цэцэгтэй атласан торго гэсэн зарахыг хориглосон бараанаас бусад барааг худалдах, дахин борлуулахыг зөвшөөрнө”⁴⁰ гэснийг Мингийн төрийн түшмэл Янь Цунжянь гэгч 1573-1583 онд бичсэн «Шуюй жоузы лу» гэдэг зохиолдоо тэмдэглэжээ.

Элчийг шагнаж, урвуулахуй. Монгол улсаас Мин улсад одсон элч нарт Мингийн хааны ордноос түшмэлийн зэрэг олгож байсан баримт цөөнгүй. Эсэнгийн үед Монголоос ирсэн гол, туслах элч нийлсэн 22 хүнийг Мин улсын төрөөс цол хэргэм өгч, эд бараагаар шагнажээ. Тэдэнд “Бүгдийн захирагч”, “Бүгдийн дохигч”, “Дохигч”, “Мянганы ноён” зэрэг албаны түшмэлийн хэргэм зэрэг олгож, тушаал дэвшүүлснээ мэдэгдэхдээ хүртээсэн зэрэг цолын дагуу чамин эд бараа дагалдуулжээ. Ийм арга хэмжээг байнга хэрэглэх болсон нь яваандаа уламжлал болж, Монгол улсын хаан, ноёдын илгээсэн элч нарт Мингийн төрөөс түшмэл зэрэг дэв, хэргэм цол шагнах явдал нь харилцааны салшгүй шахуу арга хэмжээ болж хувирчээ. Ингэж элч нарыг шагнаж байсан олон тохиолдлыг Мин улсын магад хуульд тухай бүрд нь тэмдэглэсэн байдаг.

Мингийн төрөөс гадаад худалдаандаа баримталж байсан худалдааны хоригийн бодлогын дотооддоо үзүүлсэн нөлөө. Гадаад худалдаа нь Мин улсын төрийн бүрэн хяналтдаа авсан нь, жирийн худалдаачдыг хувиараа худалдаа эрхлэх боломжийг бүрэн хааж, хорьсон үйлдэл болжээ. Ингэснээр чөлөөтэй худалдаалах хууль эрх зүйн үндэсгүй болж, улмаар хууль бус худалдаа хийхэд хүрдэг ч түүнийг

³⁹ Gıyaseddin Nakkaş. Hitay Sefaretnamesi (Haz. Betül Mutlu). Ankara, 2013, s. 62.

⁴⁰ Бокшанин А.А. Китай и страны южных морей в XIV-XVI вв. Москва, Издательство «Наука», ГРВЛ., 1968, стр. 153

нь хууль цаазаар бас хорьчихдог байжээ. Худалдаачид гадаадын элч, гадаадын худалдаачинтай холбоо тогтоох нь тэднээр дамжиж Мингийн цэрэг, улс төрийн нууц мэдээлэл алдагдах боломж үүсгэх тул үүнээс болгоомжилж, Мингийн хааны ордноос тэднийг байнга хянадаг тогтолцоог сайтар бүрдүүлжээ. Нөгөө талаар энэ хяналт нь худалдаачдаа Монголчуудад худалдахыг хориглосон бараа бүтээгдэхүүн дамлах, нууцаар худалдахаас сэргийлэх зорилготой. Ялангуяа, Монголчуудад зэр зэвсэг, төмөрлөг эдлэл буюу иргэний-цэргийн давхар зориулалттай эд бараа худалдахыг сэргийлж, ийм үйл ажиллагааг хууль бус худалдаанд тооцож, хатуу цээрлэл хүлээлгэдэг систем боловсруулж умард нутгуудад, хилийн боомт, хотуудад хэрэглэж байв. Төрөөс ингэж хатуу хянаж бас үе үе Монгол-Мингийн харилцаа хурцдаж, түүнийг нь далимдуулан Мингийн хааны ордноос – чөлөөт болон хууль цаазаар хязгаарлаж байсан худалдааг хориглосоор байсан ч хувийн худалдаа, хил дамнан наймаалахуй нь Мин улсын хил, хязгаарыг хамгаалдаг тойргууд ер нь хил дагуу бараг бүх газарт далд хэлбэрт шилжиж өргөн далайцтай тархсан байна. Монгол, Мингийн иргэдийн хооронд дэлгэрсэн албан бус далд худалдаа ийнхүү цэцэглэн хөгжсөн нь хоёр орны иргэд хоорондоо худалдаалах сонирхол асар их байсныг харуулдаг. XVII зууны эхэн үеийн мэдээгээр бол Мингийн ард иргэд адууг маш дуртай худалдан авч байсан байна. Жишээ нь, Халхын Алтан ханаас Оросын хаанд 1639 онд илгээсэн бичигт Мин “улс хүн ам их, газар нутаг өргөн уудам, улс нь хүчирхэг, хот балгад, бараа таваар, алт, мөнгө маш их. Манай хүмүүс сар гаруй явж байж Мингийн захын хотод (украинных городов) хүрдэг. Манай хүмүүс түм түмээр нь адуу хөөж аваачдаг ч хятадын захын хүмүүс (китайские украинные люди) тэд нараас агт морьдыг нэг л өдрийн дотор худалдаад авчихдаг”⁴¹ гэсэн мэдээ байна. Монгол-Мингийн жирийн иргэд “чөлөөт худалдаагаар” хэрхэн “ангаж цангаж” байсныг хожмын боловч энэхүү баримт гэрчлэх учиртай. Тиймээс хуулиар хориглодог хэдий ч хил орчмын хууль бус худалдаа цэцэглэн хөгжиж байсан бололтой. Тэр ч бүү хэл энэхүү худалдаанд хил хамгаалалтын цэргүүд татагдан орсон төдийгүй, зарим газрын хил хамгаалалтын дарга, түшмэд хүртэл нууцаар худалдаа хийж ашиг олж байлаа. Хил хязгаар дахь далд худалдааны нөхцөл байдлыг үнэлсэн Мингийн хааны ордон хууль бус худалдааг зогсоох талаар олон арга хэмжээ авч, оролцогч этгээдүүдийг шийтгэж байсан боловч амжилт олоогүйгээр барахгүй, далд худалдаа харин ч улам бүр газар авах болжээ. Ялангуяа, Жиажингийн үе буюу 1522-1567 онд Датун, Сюаньфү, Жижэнь зэрэг газарт хилийн хууль бус худалдаа хурдацтай өсөн нэмэгдэж, оролцогчид улам бүр олширч, харуулын цэрэг, захирагч дарга нар, хил орчмын ард иргэд, худалдаачид, заримдаа бүр ордны хүмүүс хүртэл далд худалдааны сүлжээнд татагдан оржээ. Тухайн нөхцөл байдлыг тэр үеийн хүмүүс “хилийн хүмүүсийн өртсөн хорлол (积蠹 jidu)” гэж нэрлэсэн гэдэг. Энэ нь тэр үед хилийн хууль бус худалдаа өргөн цар хүрээг хамарч, улам бүр их хэмжээгээр өсөн нэмэгдэж байсныг харуулж байна⁴².

⁴¹ Международные отношения в Центральной Азии XVII-XVIII вв. Документы и материалы. Книга 1. Москва, «Наука», ГРВЛ, 1989, стр. 95

⁴² 张宪功, 14-16世纪世界贸易格局中的明蒙贸易与社会控制研究, 北京: 光明日报出版社, 2023, 142页.

Худалдааг Мингийн эрх баригчид бүрэн хянаж, үр дагаварт нь хил хамгаалалтын тойргийн түшмэд цэргүүд ард иргэдтэйгээ нийлэн хилийн нууц худалдаа хийж, Монголчуудтай хуйвалдан ашиг олох болсон нь сөрөг нөлөө үзүүлж, Мин улсын умард хилийн хамгаалалтыг үлэмж хэмжээгээр сулруулжээ. Монгол-Мингийн хилийн далд худалдаа өргөжин хөгжсөөр байсан нь жирийн монгол, хятад хүмүүс чөлөөт худалдааг үгүйлж байсныг тодорхой харуулахын хамт Мин улс Монголчуудтай худалдаа хийх эдийн засгийн шаардлага, сонирхол огт байгаагүй мэт бичдэг судлаачдын үзэл баримтлал ямар ч үндэслэлгүй болохыг хангалттай харуулж байна. Монгол-Мингийн хувь худалдаачдын хилийн далд худалдаа нь Мин улсын хувьд хориотой, нууц худалдаа бол, Монголчуудын зүгээс харин төрөөс, хаад, ноёдоос дэмжлэг хүлээсэн үйл ажиллагаа байжээ. Монголын ноёд Мингийн хилийн түшмэдтэй холбоо тогтоон, тэднийг хахуулдан, далд худалдаандаа татан оролцуулах бодлогыг идэвхтэй хэрэглэх болсон ба энэ нь хилийн далд худалдаанд оролцогч жирийн иргэдийн эрх ашигт ч нийцсэн таатай бодлого байв. Гэвч Мингийн хааны ордноос үеийн үед Монгол-Мингийн худалдааг улс төрийн хөзөр болгон ашиглаж, Монголчуудын эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээ болгон ашиглаж, хааж хориглох явдал үргэлжилсээр байлаа.

МОНГОЛ-МИНГИЙН ЭЛЧИН ХАРИЛЦАА

Чөлөөт худалдааг хориглох нь улс төрийн хувь хамгийн үр ашигтай, эрсдэлгүй бөгөөд маш их зардал зарж дайтаж байлдахаас сэргийлж чаддаг үлэмж ашигтай арга бодлого байсан учраас Мин улсын хааны ордон худалдаалах бодлогоо тодорхойлохдоо Монголчуудыг ямагт гурав хувааж тус тусад нь тун ялгавартай хандаж, худалдаалж байжээ. Монголын *их хааны* захирсан «Зүүн Монгол» болон их хааны захиргаанаас ангижрахыг хүсэгч «Баруун Монгол», «Урианхайн гурван харуул» гэж хувааж харилцах нь Мин улсын эрх баригчдын ашиг сонирхолд бүрэн нийцсэн бодлого байлаа. Хувааж захирах бодлогын үр нөлөөг 1410 оны орчмоос бүр илүү ойлгосон Мингийн эрх баригчид уул бодлогыг энэ үеэс бүр эрчимжүүлжээ.⁴³ Монголчуудыг нэгтгэхгүйн тулд заримыг нь өөртөө татаж, хооронд нь өрсөлдүүлэх гэсэн Мин улсын энэ арга бол үе үеийн хятад төрүүдийн хэдэн арван зуун дамнуулан баримталсаар Мингийн үе хүргэсэн өнө эртний язгууртай хагалган бутаргах бодлогын үргэлжлэл юм.

Гэхдээ энэхүү бодлогыг Монголд элч томилж, Монголын хаад, ноёдод элдэв цол хэргэм шагнаж, тамга олгож, тансаг эд бараа бэлэглэх; эсвэл Монголоос ирсэн элчид цол хэргэм олгож, шагнаж урамшуулан сэтгэлийг урвуулж ашиглах, Монголоос ирэх элчийн тоог хязгаарлах гэсэн хоёр л замаар хэрэгжүүлж байсан учраас ордны худалдаа буюу элчин худалдааны араас хоёр орны элч нарын харилцааны тоймыг өгүүлэх нь зүйтэй болов уу.

⁴³ Wang L., Tian G. Breaking the Containment: Horse Trade between the Ming Empire and its Northern Neighbors, 1368-1570 – *Journal of World History*. Vol. 33, No. 1. Hawai'i University Press, 2022, p. 59

Мингийн элч нар. Мин улсаас Монгол улсад, их хаанд, тайшид болон Монгол улсын харьяанд байсан ч бие дааж толгой өндийлгөх болсон зүүн, баруун хоёр этгээдээр нутаглах Монголчуудыг захирдаг ноёд тэргүүлэгч нарт зарсан элчдийн талаар өгүүлье.

Ойрадын ноёдод нэг бол 1403 онд нөгөө бол 1409 онд анх элч заржээ. Мин шилу, 19, Тайзун шилу, 340-д Юнлэгийн тэргүүн оны дөрвөн сарын 6-ны хар хулгана (жэньзы) өдрийн (1403.4.26) тэмдэглэлд хаан тушааж “жэньфу Дахатэмуэр ба бусдыг илгээж Вала/Ойрадын толгойлогч Махаму, Тайпин, Батубэйлу нарт хааны зарлиг хүргүүлэв”⁴⁴ гэсэн мэдээ үлджээ. Нөгөө баримтаар бол зургаан жилийн дараа билгийн тооллын таван (1409.6.13-7.12) сард Мин улсаас Ойрадын язгууртан Махаму-д *шүнньнин* ван (順寧王 *shunning wang*), Тайванд *сянь-и* ван (賢義王 *xianyi wang*), Батболдод *аньлэ* ван (安樂王 *anle wang*) цол өргөмжилж, тамга олгожээ. Мин улсын магад хуульд энэ тухай:

“Ойрадын Махаму-г *тэжинь жиньзы гуанлү дайфу* (特進金紫光祿大夫), *шүнньнин* ван (順寧王); Тайван-г *тэжинь жиньзы гуанлү дайфу* (特進金紫光祿大夫), *сянь-и* ван (賢義王); Батболдыг *тэжинь жиньзы гуанлү дайфу* (特進金紫光祿大夫), *аньлэ* ван (安樂王) өргөмжилж, мөн тамга хүртээхийг эрхэлсэн түшмэлд тушаав”⁴⁵ гэж тэмдэглэжээ.

Монголын их хаан болон тайшийн элч нар. Монголын их хаан болон тодорхой үеүдэд хүчирхэгждэг тайши нараас илгээсэн элчийг Мингийн тал хүлээж авах эсвэл шалтаг зааж буцаасан тохиолдол цөөнгүй байдгаас дор хэдийг толилуульж байна. Монголын их хаад ихэвчлэн улс орноо нэгтгэн захирч эхлэнгүүтээ залгаад эсвэл зэрэгцүүлж, Мин улстай харилцах тал дээр анхаарлаа хандуулж тухай бүртээ тодорхой бодлого баримталж харилцааг сэргээж, сайжруулахыг оролддог аж. Тухайлбал, Тогтобуха Тайсун хаан, Тогоон тайши хоёр Мин улс руу олон удаа элч илгээхдээ худалдааны хүмүүс олныг дагуулах тул Монголын элчээс тасалж нийслэлд ирүүлэх элчийн тоог хязгаарлахыг Мин улсын хааны ордон зорьж Монголчуудад анхааруулж, шаардах болов. Жэнтуну гуравдугаар оны хаврын тэргүүн сар (1438 оны 2-р сар) гэхэд л Мин улсын хаан Датуну бүгд захирагч түшмэлд зарлиг буулгасан байна. Тэнд:

“Ойрадын Тогоон бас бараалхуулахаар хүн илгээснийг мэдсэн. Хулгай нар ихэд зальтай тул сэрэмж алдаж болохгүй. Зарлиг болгох нь, Чи даруй гол элч болох 3-5 хүнийг нийслэлд одуулж, морь, тэмээний алба бариулж, үлдсэн олон элчийг бүгдийг Датунд үлдээж, ачааны хөлс болон моринд нь хүнс бордоо өгч, иргэнтэй дураар нь арилжаа хийлгэгтүн. Цэрэг ардыг анхааруулж, харилцан зөрчилдөж болохгүй”⁴⁶ хэмээсэн байдаг.

⁴⁴ 明實錄 (Ming shilu). 太宗實錄 (taizong shilu). 永樂元年四月六日. Юнлэгийн тэргүүн оны дөрвөн сарын 6.

⁴⁵ 明實錄 (Ming shilu). 太宗實錄 (taizu shilu). Юнлэгийн 7-р оны билгийн тооллын таван сарын хөхөгчин хонь өдөр.

⁴⁶ 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жэнтуну 3-р оны цагаан сарын шар хулгана өдөр.

Зарлигийг биелүүлэхэд дэм болох үүднээс хааны ордноос элч давхиулж 800 толгой өнгөт торго явуулж Датунд үлдсэн Ойрадын элч нарыг шагнаж, алба барьсанд талархал илэрхийлж байсан юм. Тогоон тайшийн үед хамт хэрэгжүүлж байсан бодлогоо Тогтобуха хаан, Эсэн тайшитай бас хамтарч үргэлжлүүлжээ. Хаан, тайши хоёр элчийн нэрээр явагдах элчин/ордны худалдаагаар дамжуулан Мин улстай өргөн хэмжээнд худалдааны харилцаа хөгжүүлэхийг зорив. Энэ талаар Мин улсын сударт “Алба барих болгондоо эзэн, түшмэл (Тогтобуха, Эсэн нарыг хэлж байна) хамтдаа элч илгээ(хэд нь), хааны ордноос хоёр зарлигийн бичиг буулган хариу барьж, өгөөмөр шан хишгийг тэдний эхнэр хүүхэд болон аймгийн дарга нарт бас хүртээ(ж)”⁴⁷ байгаагаа тэмдэглэжээ. Энэ мэдээгээр бол Тогтобуха хаан, Эсэн тайши нар тус тусдаа төлөөний элч гаргадаг ч хамт илгээж Мин улстай харилцаж байв. Далимаар нь тэр хоёр олон тооны худалдаачид илгээж байсан учир Монголын элчийн тоо зарим үед хоёроос гурван мянгад хүрч, Мин улсад ихээхэн дарамт болж эхэлжээ. Мин улсын сударт:

“Урьд нь, Ойрадын элч 50 хүнээс хэтэрдэггүй байв. Хааны ордны хэргэм зэрэг, шан хишигт шунаж, жил бүр хоёр мянга орчим хүн болгон нэмэгдүүлэв. Удаа дараа зарлиг буулгасан боловч хүлээн авсангүй”⁴⁸

гэж тэмдэглэснээс үзэхэд, Тогтобуха хаан, Эсэн тайши нар хэдэн мянган хүнтэй элч илгээдэг болсон байна. Эдгээр элч нарын бүрэлдэхүүнд худалдаачид багтаж байсан нь тодорхой юм.

Ингэж, Тогтобуха хаан, Эсэн тайши хоёр нэгэн үе аль аль тал нь элчийг тоог нэмж, хилийн худалдааг өргөтгөх нэгдсэн бодлогыг баримталж Мин улстай харилцахдаа хамтарч байсан боловч сүүлд энэ тал дээр хоорондоо зөрчилдөж эхэлжээ. Тэднийг зөрчилдөж эхэлмэгц Мин улсын зүгээс Монголын хаан болон тайшийн буюу Монгол улсаас илгээсэн элчийг буцахад нь урьдын адил элч дагуулж илгээхийг хүссэн хүсэлтийг Мин улс хүлээж аваагүй юм.

Тэгсэн ч гэсэн Монголын хаан, тайши хоёр ч тусдаа элч илгээж харилцаагаа сайжруулахыг оролдов. Тухайлбал, 1451 оны билгийн тооллын таван сарын 23-ны цагаан бич (1451.6.21) өдөр Тогтобуха хаан элчээр захидал илгээн, элч томилон ирүүлж, найртай харилцахыг хүссэнд Мингийн хаан урьдын зарсан элч урхагтай байсан гэдгээр шалтаглан элч илгээхгүй гэдгээ мэдэгдсэнийг Мин улсын магад хуульд тэмдэглэжээ.

Эсэн тайши бас Мин улсаас элч илгээхийг хүсэхэд Мингийн ордны сайдууд хэлэлцээд “харилцааг таслах нь тэмцэл самуун үүсгэх болой” хэмээн хаандаа айлтган Монгол руу элч илгээхийг хүссэн боловч хаан нь “элч илгээх нь урьдын хэрэг бөлгөө. Урьд Ойрад халдаар ирэх цагт, элч илгээдэггүй байснаас тэгсэн хэрэг үү?” хэмээгээд, Эсэнд:

⁴⁷ 明史 (Mingshi), 卷 328 瓦剌, 8499 頁.

⁴⁸ 明史 (Mingshi), 卷 328 瓦剌, 8499 頁.

“Урьд элч илгээдэг байсан бөгөөд, өчүүхэн хүмүүний элдэв яриа, найрамдалт харилцааг таслахад хүргэсэн. Би эдүгээ дахин элч илгээхгүй хэмээн санах тул, тайши чи үүнийг гуйх нь зохисгүй”⁴⁹ хэмээн хариулжээ.

Ийнхүү Мин улсаас Монгол улс руу элч илгээхээ зогсоож “өчүүхэн хүмүүний элдэв яриа найрамдалт харилцааг таслахад хүргэсэн” гэж шалтаг болгож тайлбарлан мэдэгдэж элчин харилцааг тасалдуулжээ. Гэвч үндсэн шалтгаан нь Монгол улсын эсрэг улс төр, худалдааны хориг тавих бодлогыг Мин улс дахин баримтлах болсонтой холбоотой юм. Ингэснээр хоёр талын харилцааг хурцатгаж, худалдаанд сөрөг нөлөө үзүүлэв. Улмаар Мин улсаас элчин харилцааны нэг талыг бүрэн тасалж, зөвхөн Монгол улсаас элч, худалдаачдыг Мин улсад илгээснийг хүлээж авдаг харилцаа тогтоожээ.

Монголын нэгхэн замын цэрэгтэй Туму-д байлдаж ихээр ялагдсаныхаа дараа Мингийн эрх баригчид цэрэг зэвсгийн хүчээр Монголчуудыг ялж байсан цаг нэгэнт өнгөрснийг мэдэрч, илд мэсээр дийлэхгүйгээ ойлгосон Мингийн шинэ хаан Жинтай-гийн үеэс (景泰 jingtai, 1450-1457 он) Монгол улстай харилцах гадаад бодлогодоо өөрчлөлт оруулж, худалдааны хориг тавих бодлогод шилжиж, эхний алхам болгож элчин худалдааг хязгаарлажээ.

Монголчуудад олзлогдож байсан Инзун дахин хаан ширээнд⁵⁰ суусны дараахан үедээ Монгол улс руу элч илгээж байсан ч тогтмол болгохыг оролдсонгүй. Дараагийн хааны Чэнхуагийн үеэс (成化 chenghua, 1465-1487 он) Мин улс Монгол улс руу элч илгээхээ дахин зогсоож, улс төрийн харилцааг тусгаарлаж, энэ бодлогодоо хүч хавсаргаж худалдааны хориг тавьж эхэлжээ. Тууштай хэрэгжүүлэх болсон энэ бодлогыг баримталсан Мин улс нь Болай тайши, Муулихай ван, Орочи, Баянмөнх, Бэгэрсэн тайши нарын элчийг хүлээн авахаас удаа дараа татгалзаж, хүлээж авлаа ч гэсэн маш цөөн тооны элчийг Бээжинд нэвтрэхийг зөвшөөрөх болжээ. Жишээ болгож, Мин улсын судрын Татарын шастир дахь:

“Болай (孛來 beilai) жил бүр алба барьж, олон удаа уулгалан дээрэмдэх бөгөөд боомтын гадна ирж очин, баруун зүгт Ойрад (瓦剌 wala)-ыг довтолно хэмээгээд, басхүү олон удаа [Урианхайн] гурван харуул (三衛 sanwei)-ыг довтлон булаан дээрэмдэхийг оролдох бөлгөө. Долоодугаар оны өвөл (1463.11.10-1464.2.6) алба барих элч боомтод хүрмэгц, хуанди татгалзав”⁵¹ гэсэн мэдээг дурдъя.

Урианхай. Хянганы нурууны зүүн талд нутагтай, Чингис хааны дүү нарын захиргаанд байсан Оннигуд (Онлигуд) нар нь XIV зууны хоёрдугаар хагаст ихээхэн хүчирхэг байсан боловч 1387 онд ялагдаж, харьяанд нь байсан монгол, зүрчид ноёд Мин улсыг дагаж эхэлжээ. Тухайлбал 1388 оны 1-р сарын 16-нд зуун дөч орчим зүрчид хүмүүст Мин улсаас хувцас, цаасан мөнгө, мөнгө шагнасан

⁴⁹ 明史 (Mingshi), 卷 328 瓦剌, 8502 頁.

⁵⁰ Хааны оны цол нь Тяньшунь, 天順 tianshun, 1457-1464 он болно.

⁵¹ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8472 頁; Мин улсын судар. III боть. УБ., 2018. т. 150.

байна⁵². Монгол ноёдын хүч ийнхүү суларч эхэлсэн тул 1389 онд Монгол урианхайчууд Мин улсыг дагаснаар Урианхайн гурван харуул (Дойн/Дуянь, Тайнин, Фүй/Фуюй)-ын зохион байгуулалтад оржээ. Мин улсад алба өргөж хараат болж, гурван харуулын зохион байгуулалтад орсон Урианхай монголчууд Мин улстай худалдаа хийх, адуу арилжих эрхтэй болжээ. Юнлэ хааны үед алба өргөх гурван зуун эрх олж авсан Урианхайчууд хоёр жил тутамд элч зарж байхаар болжээ. 1406 онд Урианхайчуудад зориулж Гуаннинд адууны зах нээсэн байна.⁵³ Тиймээс зүүн гурван харуулын Монголчуудыг 1389-1400 оны хооронд Мин улсад элч илгээж ордны худалдаа хийх эрх, нийслэл орох зам маршрут, элч нарын тоо зэргийг хэлэлцэж тогтсон байх хэмээн үзлээ.

Ойрад. Ойрадын ноён Махаму 1408 оны билгийн тооллын арван сард (10.19-11.17) Мин улсын элчийг дагалдуулан Нундаши (Номдаши) нарыг элчээр зарж, Мин улсад адуу өргөн барьсан анхны тохиолдол байж мэднэ. Мин улсын магад хуульд энэ тухай:

“Ойрадын Махаму нь Нундаши нарыг Иласи нарт дагалдуулан илгээж адуугаар алба бариад, тамгаа соёрхож, хэргэм өргөмжлөхийг хичээнгүйлэн гуйв. Хаан эзэн түүний санааг сайшааж, Нундаши тэргүүтэнд хурим шагнаж, алтлаг хээтэй өвч гоёмсог торгон хувцас соёрхохыг ёслолын яаманд тушаасан”⁵⁴ гэж тэмдэглэсэн байдаг.

Мингийн хаад эрх баригчдын зүгээс гурав хувааж харилцахаар тогтсоныг дагаж элчин харилцаа хэрхэн явагдаж байсныг тоймлохыг оролдсон маань XV зууны эхэн хагасаас сүүл хагасын дунд үеийг төсөөлөх зураглал болох бол доор өгүүлэх баримтууд нь эзэнт гүрний дараах Монголын хамгийн хүчирхэгжсэн цаг үеийн элчин харилцаа, ордны худалдааг тусган харуулах тойм юм.

Даян хааны эрин. Юуны өмнө, Батмөнх даян хааны үед Монгол улс нэгдмэл бодлогоор Мин улстай харилцах болж, удаа дараа элч илгээж байсныг тэмдэглэе. Гэвч Мингийн хааны ордон хориглох бодлогоо баримталсаар байлаа. Тийм хэдий ч Батмөнх даян хаан хүчирхэгжин, Монголчуудыг нэгтгэснээр Монгол-Мингийн худалдааны харилцаа өмнөх үеэ бодвол харьцангуй идэвхжиж шинэ үе эхэлсэн гэж үзэх боломжтой. Батмөнх даян хаан 1484 онд Мин улсын хаанд захидал илгээж, худалдааны харилцаа сэргээхийг хүссэн боловч амжилт олоогүй юм. Хунжи (弘治 hongzhi, 1488-1505 он)-гийн тэргүүн он 1488 оны билгийн тооллын таван сард (6.10-7.8) Батмөнх даян хаан “бичиг өргөн барьж, алба барихыг гуйв. Бичгийн үг тэрслүү хатуу ба өөрийгөө Их Юань улсын Их хаан хэмээн нэрлэжээ” гэсэн баримт үлджээ. Зургаан сард (7.9-8.6) элч зарсан талаар Датун хилийн түшмэл “эдүгээ хаан (сяованзы) хуандигийн залгамжлагч нарт элч илгээн

⁵² Мелихов Г.В. Политика минской империи в отношении чжурчженей (1402-1413 гг.) – *Kumai u соседи в древности и средневековье*. Отв. ред. С.Л.Тихвинский, Л.С.Переломов. Москва, Изд-во «Наука», ГРВЛ, 1970, стр. 252

⁵³ Wang L., Tian G. Breaking the Containment: Horse Trade between the Ming Empire and its Northern Neighbors, 1368-1570 – *Journal of World History*. Vol. 33, No. 1. Hawai'i University Press, 2022, p. 50

⁵⁴ 明實錄 (Ming shilu). 太宗實錄 (taizu shilu). Юнлэ-ын 6-р оны билгийн арван сарын улаагчин хулгана өдөр.

алба барьж байна. Түүний илгээсэн харийн хүн 1,539, морь тэмээ 4,930 хилээр орж ирснийг Датунд байрлуулав” хэмээн хаандаа айлтгасныг Мин улсын магад хуульд тэмдэглэжээ⁵⁵. Батмөнх даян хаан ихээхэн хүчирхэгжиж, Мин улсын хил хязгаарт их хүчээр халдаж, хааны ордныг нь сандаргасан тул Мин улс арга буюу худалдаа хийх саналыг хүлээн авчээ. Монгол-Мингийн худалдааны харилцаа ийнхүү сэргэж эхлэв. 1490 оны хоёр сард (2.19-3.20) холбогдох Мин улсын магад хуулийн мэдээнд, урьд хааны зарлигаар “умардаас нэг мянга нэг зуун хүнийг боомтоор нэвтрүүлж, 400 хүнээр алба бариулахаар тогтсон”⁵⁶ гэж тэмдэглэснээс үзвэл Мин улс хязгаарлагдмал тооны элчийг Бээжин орохыг зөвшөөрчээ. 1496 оны таван сард (5.24-6.21) Батмөнх даян хааны 3,000 хүний бүрэлдэхүүнтэй элч боомтоор нэвтэрч Бээжин орохыг хүсэхэд, Мингийн хааны ордноос мянган хүнийг нь оруулахаас татгалзаж, элчийн тоог хязгаарласан юм. 1504 оны гурван сард (3.16-4.14) зургаан мянган хүний бүрэлдэхүүнтэй элч илгээхэд, олон жилийн жишгээр “зарлигаар 2,000 хүнээр алба бариулахыг” зөвшөөрсөн⁵⁷ гэжээ. Эндээс үзэхэд, Батмөнх даян хааны үед Бээжинд очих элчийн тоог хоёр мянган хүнээр Мин улс хязгаарлаж байсан хэмээн үзэж болохоор байгаа юм. Гэвч Мин улсын тусгаарлах, худалдааны хориг тавих бодлогын улмаас энэхүү харилцаа удаан тогтвортой үргэлжилсэнгүй. Мингийн талаас худалдааны харилцааг тасалдуулж, үүний улмаас Батмөнх даян хаан хил хязгаарт уулгалан довтлох үйл явц үргэлжилсээр байсан билээ.

Батмөнх хааны дараах үе. 1532 онд Монголын их хаан мөн элч илгээн, харилцаагаа сэргээхийг хүссэн боловч Мингийн талаас татгалзжээ. 1533 онд монгол ноёд хилийн зах нээх хүсэлт тавьсан ч Мингийн хааны ордон зөвшөөрсөнгүй. Энэ талаар Мин улсын сударт “арван нэгэн оны хавар (1532.2.6-5.4) хаан (小王子, сяованзы) алба барьж харилцахыг гуйсан ч зөвшөөрөл олж чадаагүй тул хилэгнэн, хэдэн арван түмэн морьт цэрэг дагуулж уулгалан довтлов” хэмээжээ. Мингийн түшмэлүүд Монголчуудын хүсэлтийг “зөвшөөрөхийг гуйсан боловч, хуанди сонссонгүй”⁵⁸ гэсэн байна. Сурвалжийн дээрх мэдээ нь Монголчууд ямар шалтгааны улмаас Мингийн хил хязгаарт халдан довтолдог байсныг маш тодорхой харуулсан чухал баримтын нэг болно.

Мин улс XVI зууны эхэн хагаст ч гэсэн Монгол улсын эсрэг эдийн засгийн хориг тавьж, худалдаа хийхгүй байх бодлогыг тууштай баримталсан хэвээр байжээ. Мин улсын гадаад харилцааны энэхүү “тусгаарлах бодлогын” талаар “Бодлогын энэхүү өөрчлөлт нь Мин улсын эхэн үеийн Монголыг хянах идэвхтэй бодлоготой адилгүй [бөгөөд] Мин улсын дунд үеийн хилийн болон Монголын талаарх бодлого назгайрсан, идэвхгүй, хаалттай хуучинсаг бодлого болон өөрчлөгдсөн” хэмээсэн хятад судлаач залгуулаад “алба барих худалдааг идэвхгүй

⁵⁵ 明實錄 (Ming shilu). 孝宗實錄 (Xiaoazong shilu). Хунжийн тэргүүн оны таван сарын 22-ны хөхөгчин тахиа өдөр (1488.6.1); Хунжийн тэргүүн оны 6 сарын хөхөгчин тахиа өдөр

⁵⁶ 明實錄 (Ming shilu). 孝宗實錄 (Xiaoazong shilu). Хунжийн 3-р оны 2 сарын харагчин могой өдөр

⁵⁷ 明實錄 (Ming shilu). 孝宗實錄 (Xiaoazong shilu). Хунжийн 9-р оны 5 сарын хөхөгчин хонь өдөр; Хунжийн 17-р оны 3 сарын хар морь өдөр

⁵⁸ 明史 (Mingshi), 卷 327 韃靼, 8478 頁.

хориглож, олон талаар хязгаарласаар ... Монголын төртэй худалдаа хийхээс эрс татгалзсан нь цагаан хэрмийн өмнөд, умардын эдийн засгийн холбоог зохиомлоор тусгаарласан юм” гэж бичиж дүгнэжээ⁵⁹.

Мин улсын талаас Монголчуудыг улс төрийн хувьд тусгаарлаж, худалдааны хориг тавих бодлогыг 1450-иад оноос баримтлах болж, улмаар Чэнхуа (成化 chenghua, 1465-1487 он)-гийн үеэс тууштай хэрэгжүүлснээр хоёр улсын элчин (ордны) худалдаа болон хилийн худалдаа зогсонги байдалд орж, зарим үед удаан хугацаанд тасалддаг байдал 1571 онд Алтан хан-Мин улстай гэрээ байгуулах хүртэл үргэлжилсэн юм.

ХИЛИЙН ХУДАЛДАА: АДУУНЫ ЗАХ (馬市 MASHI)

Монгол-Мингийн хооронд хөгжсөн гадаад худалдааны нэг хэлбэр нь хилийн худалдаа юм. Мин улс нь Юань улсын адууны аж ахуйн уламжлалыг сэргээн хөгжүүлэхийг оролдож байсан ч төдийлөн амжилт олсонгүй. Адууны бэлчээр бага, хомсдолтойгоос гадна адууг маллан өсгөж үржүүлэх мэдлэг ухаан дутагдалтай эсвэл бараг байхгүй байсан нь үүнд нөлөөлжээ. Түүнчлэн, хятад судлаачдын бичсэнээр бол “адуу өсгөх зардал аймшигтай” байсан⁶⁰ тул хямд үнээр хоёроос гурван төрлийн бараагаар Дундад Ази, Түвэд, Солонгос, Монголоос адуу худалдан авах нь эдийн засгийн хувьд хамаагүй үр өгөөжтэй байж, түүнд ихээхэн анхаарал хандуулж, тусгай бодлого боловсруулан хэрэгжүүлжээ. Гэвч Мин улс нь эхэн үедээ адууг дотооддоо өсгөж үржүүлэх замаар дутуугаа нөхөх, хараат байдлаас гарах оролдлого хийж байсныг ойлгохгүйгээр хилийн худалдаа-адууны захын цаад далд учрыг олж харах боломжгүй. Тиймээс Мин улсыг XIV-XV зууны заагт Хун-у, Юнлэ хаан захирч байх үеийн адуу (цэргийн агт) талаар авч хэрэгжүүлсэн бодлогыг эхлээд авч үзье. Мин улс байгуулагдсан цагаасаа цэргийн агтанд онцгой анхаарал хандуулж Хааны адуун сүргийн товчоо⁶¹ (Taipusi, 太僕寺)-г Дайны/Цэргийн яам (Bingbu, 兵部)-ны шууд захиргаанд байгуулж Мин улсын дотоод мужуудын адуу үржүүлгийг хариуцуулжээ.⁶² Мөн Мин улс Наньжинд нийслэллэх үед, адууг өсгөж үржүүлэх ажлыг хариуцсан бүтэц 1373 онд байгуулагдсан⁶³ юм.

⁵⁹ Юй Мо-Ин. “Түмү-гийн хэрэг явдал”-аас “Лунчун”-гийн энхийн хэлэлцээр хүртэлх үед Мин улсаас Монголын талаар баримталж байсан идэвхгүй хориглон хамгаалах бодлого. *Studia Historica*. Tomus L, Fas. 18. УБ., 2021. т. 314.

⁶⁰ Wang L., Tian G. Breaking the Containment: Horse Trade between the Ming Empire and its Northern Neighbors, 1368-1570 – *Journal of World History*. Vol. 33, No. 1. Hawai'i University Press, 2022, p. 41

⁶¹ Тайпусы-гийн үндсэн үүрэг бол хянан байцаах ажил байжээ, үүнд – сүргийн тоо толгой, үржсэн эсэх, жин, эрүүл өвчтэй эсэх (нүд, шүд, өнгө зүс гэх мэт)-ийг хянан байцааж дээш айлтган илтгэж, ажлаа цалгардуулж, улсад хохирол учруулсныг өргөн мэдүүлж, торгох, заримдаа баривчилж шийтгэдэг байжээ (明史(Mingshi), 卷七十四 (juan 74), 職官三 太僕寺 (zhiguansan, taipusi), 1800 頁; 明史(Mingshi), 卷七十五 (juan 75), 職官四 行太僕寺 (zhiguansi, xingtaipusi), 1845 頁).

⁶² Hucker, Charles O. Governmental Organization of the Ming Dynasty – *Harvard Journal of Asiatic Studies*. Vol. 21. December 1958. Harvard-Yenching Institute, 1958, p. 35

⁶³ Grass N. A Million Horses: Raising Government Horse in Early Ming China – *Animals and Human*

Наньжинд байгуулсан Тайпуси-гийн үйл ажиллагааны талаарх мэдээ бий. Тэнд өгүүлэхээр, голын (Шар мөрөн) өмнөх 15 мянган өрх хариуцсан адуу 1377 онд 2,380 толгойгоор, мөн өөр нэг баримтаар 1400-аад оны эхэнд гурван жилийн хугацаанд 6,197 толгойгоор нэмэгдэж байжээ. Зарим жил олон унага бойжуулж чадаж байсан ба 1394 онд 10,700 унагатай болжээ. Гэвч энэ бүхэн Жу Юаньжаны санаанд хүрэхгүй байсан тул Мин улсын умард хилийн цайз шивээ, тойргийн нутагт адуу үржүүлэхийг 1397 онд шинээр байгуулсан Шинтайпусы (Xingtaipusi, 行太僕寺)-д хариуцуулжээ. Гэхдээ энэ захиргааны мэдэлд өмнө нь 1380 онд Бэйпин (北平, beiping), Шэньси, Шаньси болон Ганьсу, Ляодунд байгуулчихсан байсан адуу сүрэг, захиргааг шилжүүлснээр Мин улсын умард хилийн дагуу байрлах адуу сүргийг хянаж байцаах үүргийг Шинтайпусы бүрэн даав. Шинэ товчоо байгуулагдахад зарим монгол ноёд албат иргэдтэйгээ Мингийн хилд ойр нутаглаж, дагах болсон явдал нөлөөлжээ. Юнлэ хаан Бээжинг нийслэл хот болгосны дараа 1419 онд Шинтайпусы-г Тайпусы-тай нэгтгэсэн юм. Зохион байгуулалтын тал ийм арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

Харин Мин улсын зүгээс хэрхэн адуу худалдан авч байсныг нэлээд нарийвчлан авч үзэх баримт мэдээ харьцангуй их ажээ. Тухайлбал, Мин улс эхэн үедээ ямар аргаар агт морьд худалдаж авч байсныг Мингийн бичгийн хүмүүн Ван Шижэнь (1526-1590) «Яньшаньтан бижи» хэмээх 1590 онд бичиж дуусгасан зуун боть зохиолынхоо 89-р бүлэгт нэлээд тодорхой тэмдэглэжээ. Мингийн эхэн үеийн төрийн албан баримт бичгээс шууд хуулж оруулсан учраас сэдэв болгон дээрээ чухал ач холбогдолтой сурвалж болно гэж үнэлэгдэх энэхүү зохиолын 89-р бүлэгт тэмдэглэсэн оноор бол Хун-у-гийн 7-р оноос Жу Хоуцун хааны Жиажин-ы 30-р оны хоорондох зуун далан хэдэн жил буюу 1378-1551 онд Мин улсаас цэргийн агт морьдын тоо хангамжийг гаднаас худалдан авах замаар хэрхэн хангаж байсан үйл явдлыг нарийн тоочиж бичиж үлдээжээ.

Ван Шижэнь-ий зохиолын мэдээ баримтыг харгалзан үзвэл XIV зууны далаад оноос XV зууны тавиад он хүртэл Мин улсын адуун бодлого, авсан арга хэмжээг гурав хувааж судлах боломжтой юм байна. Хун-у хааны бодлого нь Юнлэ хааны авч хэрэгжүүлсэн бодлого арга хэмжээнээс нэлээд ялгаатай бол 1425 оноос хойших Мин улсын цэргийн агтны хангамжийн тал дээрх бодлого, арга бас жаахан өөр болсон байх жишээтэй. Тиймээс Хун-у болон Юнлэ хааны бодлогыг тус тусад авч үзэх бололцоотой ажээ. 1374 онд 250 агт морь худалдан авсан мэдээг дурдсан Ван Шижэнь 1376 онд Гуандунд адууны өссөнийг тэмдэглэсэн байдаг. XIV зууны далаад онд адууг худалдан авахдаа Мингийн түшмэд цайнаас гадна давс, мөнгийг төлбөрийн хэрэгслээр ашиглаж байжээ. Түүнчлэн энэ үед Монголчуудаас анх адуу бэлгэнд авсан тохиолдол гарчээ. Их Монгол улсын үеэр бол Өгэдэй хааны хүү Гүдэний удмынхны эзэмшил болох Ганьсугийн Хэси хонгилд нутагтай⁶⁴ Монголчуудаас 1378 онд Мингийн түшмэл 469 агт морь

Society in Asia. Historical, Cultural and Ethical Perspectives. Editors R.Kowner, G.Bar-Oz, M.Biran, M.Shahar, G.Shelach-Lavi. Palgrave Macmillan, 2021, p. 306

⁶⁴ Мингийн захиргаа тэдгээр монголчуудыг Ханьдун (罕東, handong) харуул гэж нэрлэжээ. Дуньхуаны баруун өмнө холгүй байсан.

худалдан авсан байна.⁶⁵ Одоогоор байгаа эхний баримт гэж болох байх. Үүний дараа 1388 онд Монголчуудаас их хэмжээгээр агт морьд худалдан авчээ. Хэд хэдэн ноён бүхий хоёр бүлэг Монголчууд нийт 8,697 морь бэлэглэж, заржээ.

Хун-у хаан агт морьдын тоо толгой буурч байгаад санаа зовниж, цэргийн агт худалдан авалтыг зохион байгуулахдаа баруун өмнө зүгийн Гуйжоу, Юньнань болон баруун зүгийн Сычуаний хязгаарт нутаглах хятад бус ард иргэдээс мөнгө, цай, давс, цаасан мөнгөөр, заримдаа торго, бөс даавуугаар арилжиж авах бодлого боловсруулсан талаарх мэдээ дурдсан сурвалжид үлджээ. Тухайлбал, цайгаар адуу худалдаж авахдаа хоёр үнэ ханш тогтоожээ. Шэньсид нутагладаг Түвэдүүдээс морийг сайн, дундаж, муу хэмээн ангилж 120, 70, 50 жингийн цайгаар морь авч байсан бол баруун өмнө зүгийнхнээс 40, 30, 20 жин цайгаар агт худалдаж авч байжээ. Энэ аргаар 1378-1384 онд 8,268 агт морь худалдаж авчээ. Адууг олон тоогоор авах зүй ёсны хэрэгцээ байсныг 1385 оны тооллогын дүн харуулна. Тайпусы товчооны бүртгэлээр хоёр газрын 8 сүрэгт нийт 25,915 морь тоологдсон бол дараа жил нь гэхэд зөвхөн Шэньсийн захаар дамжуулж 6,729 агт морь худалдаж авсан байна.⁶⁶

Хун-у-гийн үеийн Мин улсын адуу худалдан авах бодлого нь болж өгвөл Монголчуудаас адуу авахгүй байх гэсэн зарчимтай байсан мэт харагддаг. Тиймээс Ляодунгаар дамжуулж Солонгосоос (Корё), Гуйжоу, Юньнань зэрэг газрын хятад бус ард иргэдээс, Сычуань-Шэньсийн захаар дамжуулж Түвэдүүдээс адуу худалдан авч байжээ. Сүүлээр энэ худалдаанд Самаркандаас ихэвчлэн ирэх болсон Төмөрийн улсын худалдаачид (элч⁶⁷ дагаж аялж ирсэн) нэмэгдсэн ч тэд их хэмжээний адуу авчирч чаддаггүй байжээ. 1387 онд анх 15 морьтой ирж байсан тэдгээр Төмөрийн улсын элчин ба худалдаачид 1388 онд 300 адуу, 1396 онд 1,095 морь авчирч заржээ. Энэ хооронд 1389-1385 онд нийт бараг 1,400 агт морь авчирчээ. Газар хол нь нөлөөлсөн байж болох ч цөөн тоогоор хурдан удмын адууг өндөр үнээр зарах сонирхлоосоо болсон ч байж мэднэ.

Хун-у-гийн үед буюу 1378-1397 оны хооронд 107,434⁶⁸ агт морь худалдан авсны 43,6 хувийг Түвэдүүдээс, 35,4 хувийг Солонгосчуудаас, 8,54 хувийг баруун өмнө зүгийнхнээс, 3,8 хувийг баруун цагадайчуудаас худалдан авсан бол Монголчуудаас хоёрхон тохиолдлоор 9,100 орчим адуу худалдаж авсан нь нийт импортолсон адууны 8.53 хувь болж байна.

⁶⁵ 明實錄 (Ming shilu). 太祖實錄 (Taizu shilu). 卷一百四至一三十三 (juan 140-133)

⁶⁶ 王世真 (wangshizhen). 弇山堂別集 (yanshantangbieji). 臺北 (taipei). 臺灣學生書 (Taiwan xuesengshu). 1965, 3923-3933頁

⁶⁷ 1388 онд ирсэн элчийн багт 59 хүн ирсэн бол 1396 онд 191 хүнтэй элч Мингийн хил давжээ.

⁶⁸ Бүрэн бус мэдээгээр – 1378 онд 3,065, 1381 онд 1,847, 1384 онд 5,916, 1385 онд Солонгосоос 5,000, 1386 онд Түвэд, Солонгосоос 14,769, 1387 онд Солонгосоос 3,040, Түвэдээс 2,807, нийт 6,032, 1388 онд Монголчуудаас 8,697, нийт 9,297, 1389 онд 410 адуу, 1390 онд Шэньсийн захаар 7,060, нийт 7,778, 1392 онд Түвэдээс 10,340, Солонгосоос 10,000, нийт 20,424, 1394 онд Солонгосоос 9,894 адуу, нийт 10,094, 1395 онд 240 адуу, 1,396 онд Төмөрийн улсаас 1,095, нийт 1,307, 1397 онд Түвэдүүдээс 1,560, Төмөрийн улс 1,335, нийт 2,895, 1398/99 онд 13,518 адууг Сипаньчуудаас авч байжээ.

Ийнхүү худалдан авахаас гадна дотоодын адууны аж ахуйнууд ч өсөх хандлагатай болжээ. 1395 онд 9,407 унагаар адууны тоо толгой нэмэгджээ. Гэхдээ ингэж хэдэн мянгаар нэмэгдэх явдал төдийлөн жил дараалан гарч чаддаггүй байсан бололтой. Зарим жил адууны тоо толгой тун бага нэмэгдэж байжээ.

Гэхдээ Жу Юаньжаны үед авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ нь Мингийн цэргийн агтны нөхцөл байдлыг тодорхой хэмжээгээр ахиулж чадсан ч хангалттай түвшинд хүрээгүйг дараах баримтаас харна уу. Хун-у-гийн 30-р оны билгийн тооллын зургаан сарын 10-ын цагаан бар өдрийн (1397.7.4) орчим Жу Юаньжанаас Жинь ванд, манай улс Ляодунгаас Ганьсу хүртэл зургаан мянгаад ли (3359/60 км) үргэлжлэх хил дээрээ зуун мянгаадхан цэргийн агттай буй. Нийслэл болон Хэнань, Шаньдунд агт морьд бий ч үтэр түргэн хил рүү шилжүүлэх боломжгүй. Бачим хэрэг гарахад даваа, боомтын ард илгээх агтны тоо Бэйпинд дөнгөж хоёр түмд л хүрнэ⁶⁹ гэж хэлүүлжээ. Хааны шийдвэргүйгээр сахиж суусан хотоосоо гарч дайсны нутаг дураараа довтолж одсон ванд хэлүүлсэн энэхүү үгээс үзэхэд, тэрбээр Мингийн цэргийн агтны тоо толгойг чамлаж байсан нь харагддаг. Түүнийг 1398 оны 6-р сард нас барсны дараа байдал бүр доройтжээ. Жу Ди (Юнлэ) хаан болохоосоо өмнө цэргийн сайдаасаа Мингийн цэргийн агт 27 мянга байгааг олж мэдсэн⁷⁰ нь үүнийг гэрчлэх байх. Тиймээс хаан болонгуутаа цэргийн агтанд анхаарсан Юнлэ дахин нэг шинэ бүтэц бий болгосон ба 1405 онд дөрвөн Юаньмасы (Yuanmasi, 苑馬寺) хэмээх газрыг Цэргийн яамны хяналтанд байгуулжээ.⁷¹ Ингэснээр Мин улсад 1405-1419 онд адууны хэрэг эрхлэх төрийн гурван байгууллага зэрэгцэн үйл ажиллагаа явуулж болжээ.

Юаньмасы нь тус бүртээ харьяат зургаан захиргаагаар дамжуулан 24 томоохон адуун сүрэг, бэлчээрийнх нь аливаа асуудлыг хариуцдаг дөрвөн хяналтын хэлтэстэй энэхүү алба/товчоо нь Дайны яамны өмнө ажил үүргээ тайлагнаж, шийдвэр тушаалыг нь биелүүлдэг захиргааны бүтэц байжээ. Юаньмасы-н харьяа хяналтын хэлтэс Бэйжили, Ляодун, Ганьсу, Пинлян (Шэньси)-д тус бүр нэг байсан нь дөрвөн том төвлөрсөн захиргаа/хяналтын хэлтэс байгуулсан гэсэн үг. Энэ газрууд дор бүрээ зургаан адуун сүргийн захиргаагаар дамжуулж 24 бэлчээрийг хянаж хариуцдаг. Нийт 96 бэлчээр улсын мэдэлд байсан гэсэн үг. Юаньмасы буюу адууны хэрэг эрхлэх захиргааны мэдэлд байсан бэлчээрийг⁷² – нэгдүгээр (上) зэргийнх түмэн адуу бэлчээрлэх талбайтай, дунд (中) зэргийнх 7 мянган адуу, харин хамгийн доод (下) зэрэглэлийнх 4

⁶⁹ 明實錄 (Ming shilu). 太祖實錄 (Taizu shilu). 卷 二百五十三 (juan 253).

⁷⁰ Grass N. A Million Horses: Raising Government Horses in Early Ming China – *Animals and Human Society in Asia. Historical, Cultural and Ethical Perspectives*. Editors R.Kowner, G.Bar-Oz, M.Biran, M.Shahar, G.Shelach-Lavi. Palgrave Macmillan, 2021, p. 299

⁷¹ 1405 онд Бэйпин, Ляодунд, харин 1407 онд дахин хоёрыг хяналтын хэлтсийг Ганьсу, Пинлянд байгуулжээ.

⁷² Гурван зэрэглэлийн бэлчээрийг – бэлчээр/нуга, ашиглаагүй өнжөөж буй талбай, боловсруулж буй газар, цэвэрлэж байгаа талбай, хориг гэж бас дотор нь хувааж ашиглаж байжээ.

мянган адуу багтаахаар ангилжээ.⁷³ Улсын мэдлийн эдгээр бэлчээрт ойролцоогоор 384 мянгаас 960 мянган толгой адууг байнга бэлчээж, барьж байх боломжтойг судлаачид тооцоолжээ.⁷⁴

Адуу өсгөж үржүүлэх ажил нь язгуураас тариачин гаралтай энгийн иргэдэд маш хүнд хөдөлмөр болж байжээ. Тиймээс Мингийн төрийн зүгээс заримдаа тариачдыг илгээлгүй өөр арга хэмжээ авах тохиолдол нэг бус удаа гарч байв. Мин улсын сударт тэмдэглэснээр бол цаазын ялтай, бусад элдэв хүнд хэрэг үйлдэж хүнд ял авсан гэмтнүүдийг Монголын хилтэй залгаа орших Шэньсийн мужийн Тайпусы-(хуучнаар Шинтайпусы)-гийн мэдэлд өгч адууны сүрэгт төрийн боол болгон ажиллуулж ашиглаж байжээ⁷⁵. Энэхүү баримтаас харвал Мин улсын жирийн ард иргэд төрийн мэдлийн адуун сүргийн газарт ажиллах тун дургүй байсан бололтой.

Улсын зүгээс тусгайлан сонгосон бэлчээрийг язгууртан ноёд хувьдаа ашиглах, хагалбарлах гэх мэтээр хороож байсныг судлаачид тэмдэглэсэн байдаг. Зөвхөн Шэньсид гэхэд 2 сая му талбайны хагасыг газар тариалангийн зориулалтаар хэрэглэж байсныг XVI зууны эхээр тэнд ажилласан байцаагч түшмэл дээш мэдэгдэж байв.⁷⁶

Ийнхүү Хун-у, Юнлэ хааны үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд Мин улс нь богинохон хугацаанд⁷⁷ ч болов өмнөх хятадын төрүүдтэй харьцуулахад харьцангуй их адуутай болж чаджээ.

Дотооддоо ингэж адуу өсгөж үржүүлэх бодлого барихын зэрэгцээ Мин улс хөрш орнуудаа алба барьдаг, эс барьдгаар нь ялгаж бас зүг чигээр хувааж, хилийн боомт зах нээж, аль газраас адууг нь юугаар буюу цай, торго эсвэл өөр бусад бараагаар худалдаж авах зохицуулалт хийж байсныг бага зэрэг дэлгэрүүлэн авч үзье. XV зууны эхэн үеэс Мин улс хилийн худалдааны амин сүнс нь болсон “адууны зах” байгуулж эхэлсэн бөгөөд зүүн хойд болон умардын нүүдэлчдээс адууг торго болон мөнгөөр, баруун хойдын зүгийнхэн болон лалын худалдаачдаас цайгаар худалдан авч эхэлжээ. Энэ нь тухайн бүс нутгийн ард түмэнд хамгийн эрэлттэй бүтээгдэхүүнээр адууг худалдан авах гэсэн Мин улсын бодлогын илрэл болно. Ялангуяа баруун, баруун хойд зүгийн ард түмнүүдтэй хийж байсан худалдааны гол бараа нь цай бөгөөд гадаад зах зээлд хамгийн эрэлттэй бараа байсан тул Мин улсын хааны ордноос төрийн монополь тогтоож, Шэньси,

⁷³ 明史 (Mingshi), 卷七十五 (juan 75), 職官四. 苑馬寺 (zhiguansi, yuanmasi), 1846頁

⁷⁴ Grass N. A Million Horses: Raising Government Horses in Early Ming China – *Animals and Human Society in Asia. Historical, Cultural and Ethical Perspectives*. Editors R.Kowner, G.Bar-Oz, M.Biran, M.Shahar, G.Shelach-Lavi. Palgrave Machmillan, 2021, p. 313

⁷⁵ 明史 (Mingshi), 卷七十五 (juan 75), 職官四 行太僕寺 (zhiguansi, xingtaipusi), 1845頁

⁷⁶ Grass N. A Million Horses: Raising Government Horses in Early Ming China – *Animals and Human Society in Asia. Historical, Cultural and Ethical Perspectives*. Editors R.Kowner, G.Bar-Oz, M.Biran, M.Shahar, G.Shelach-Lavi. Palgrave Machmillan, 2021, p. 319

⁷⁷ 1420 онд адуун тоо нь 782,4 мянгад хүрсэн бол 1425 онд 1,78 сая болжээ. Гэхдээ энэ байдал удаан үргэлжлээгүй бөгөөд XV зууны хориод оны сүүл гучаад он гэхэд адууны тоо толгой дахиад буурсан бололтой. Хань улс 3 бум, Тан улс 7 бум, Сүн улс 745 мянган орчим цэргийн агттай байсан гэж судлаачид бичжээ (Ноа Грассын өгүүллийг үзнэ үү.).

Сычуаний захын үндсэн бараа болгожээ. Сычуанийг сонгосон шалтгаан бол Сычуань нь цайгаараа алдартай, хамгийн их цай нийлүүлдэг бүс нутаг байсантай холбоотой бол Шэньси нь баруун хойд болон умардын нүүдэлчидтэй хил залгаа ойрхон нутаг байв. Мөн Шэньсийг сонгоход Сычуань нь зах зээлээс нэлээд зайтай байдаг явдал нөлөөлжээ. Шэньсийн захуудыг нээснээр Сычуаний адуу худалдаж авах газруудыг хааж, тэндхийн цайг Шэньси рүү тээвэрлэх ажлыг зохион байгуулжээ, зарим баримтаар цэргийнхэн тээврийг хариуцаж байжээ. 1389 онд Мин улсын хааны зарлигаар Адууны худалдааны газар нь сайн морийг 120 жин, дундад морийг 70 жин, дунджаас доогуур морийг 50 жин цайгаар худалдан авах жишиг үнэ тогтоов. Үүнээс гадна худалдаа эрхлэх гол газар болсон Шэньси мужид хэдэн салбар нээв, тухайлбал, Хэжоугийн салбар нь 1374 онд, Таожоу-гийн салбар 1483 оноос өмнө, Синин-ий салбар 1397 онд, Ганьжоу-гийн салбар 1413 онд тус тус байгуулагдсан ба Миньжоу, Жуанланд салбар нээжээ⁷⁸.

Цай болон тээврийн улсын монополиос болж хувь худалдаачдад хязгаарлагдмал хэмжээний цай борлуулах эрх олгож байв. Харин зөвшөөрөлгүй хил давуулан цай борлуулсан худалдаачдад хатуу шийтгэл оноох замаар чанга хатуу хяналт тогтоосны ачаар Мингийн цэргийн агтны хангамж сайжирч эхэлжээ. Цайг нууцаар хил дамнуулан худалдаалах явдлыг таслахын тулд хаврын сүүлээс бараг өвлийн эх хүртэлх хугацаанд Шэньсид тусгай түшмэл томилж гол гол худалдааны зам, харгуй дээр, боомт даваа бараадуулж байрлуулан өнгөрөгсдийг хатуу шалгадаг тогтолцоо бий болгосон байна. Мөн жирийн тариачид цайг удаан хугацаагаар хадгалахыг хорьж, энэ бүхнийг зөрчвөл тариан талбайг нь шууд хурааж авдаг байжээ.

Юнлэ хааны үед цэргийн агтны хэрэгцээ дахин эрс өсчээ. Монгол улс руу олон удаагийн нүсэр аян дайн хийсэн нь Мингийн цэргийн агтны хэрэгцээг үлэмж нэмэгдүүлсэн юм. Энэ үед адууны худалдааны нэг салбар агт морьдыг 80 мянган жин цайгаар худалдан авч байсан баримт байна. Нэг морийг мянга гаруй жин цайгаар авч, адууны үнэ огцом өсжээ. Юнлэ хааны 13-р он буюу 1415 оноос Мингийн цэргийн агтны тоо эрс нэмэгдэж, 1415/16 оны заагт 310,617 адуу, 1417/18 оны заагт 514,439 адуу, 1422/23 оны заагт 1,199,315 болсон юм.⁷⁹ Мингийн адууны тоо толгой хэдхэн жилийн дотор ингэж өссөнийг Моррис Россабид, Мингийн адууны тоо толгой ийнхүү их хурдацтай огцом өссөн явдал бол Юнлэгийн үеийн ерөнхий хандлага⁸⁰ юм гэж дүгнэсэн. Харин зарим судлаач адууны тоо толгой ингэж огцом нэмэгдсэнийг дотоодын адууны аж ахуйтай

⁷⁸ Rossabi. M. The Tea and Horse Trade with Inner Asia During the Ming. *Journal of Asian History*. Vol. 4, No. 2 (1970), p. 143.

⁷⁹ Rossabi. M. The Tea and Horse Trade with Inner Asia During the Ming. *Journal of Asian History*. Vol. 4, No. 2 (1970), p. 148 note 56; Grass N. A Million Horses: Raising Government Horses in Early Ming China – *Animals and Human Society in Asia. Historical, Cultural and Ethical Perspectives*. Editors R.Kowner, G.Bar-Oz, M.Biran, M.Shahar, G.Shelach-Lavi. Palgrave Macmillan, 2021, p. 301 Table 10.1

⁸⁰ Моррис Россабийн өгүүллийн 148-р талын зүүлт 56-г харна уу.

холбож, гаднаас нэг жилд “хэдэн мянган адуу” гаднаас худалдан авч байсан хэмээн өгүүлжээ⁸¹.

Гэтэл «Азийн хүний нийгэм ба амьтад» гэсэн эмхэтгэл дэх Ноа Грассын хүснэгтийг харвал Юнлэ хааны эхэн үед Мингийн албаны сүргүүдийн адууны тоо толгой тогтмол шахуу арваад мянгаар нэмэгдэж байснаа гэнэт хорин хэдэн мянгаас – зуун дөч тавиад мянгаар, зарим жил зуун жар орчим мянгаар, цөөн хэдэн жилд нь бүр дөрвөн зуу шахсан мянган толгойгоор нэмэгдэж эхэлжээ.⁸² Адууны тоо толгой ингэж огцом өсөх нэг эх сурвалж нь яах аргагүй гадаад худалдан авалт юм. Өөрөөр хэлбэл, Мин улсын цэргийн агтны худалдан авалт найман жилийн дотор хэд дахин өсөж, үлэмж хэмжээний мөнгө мөн дүйцүүлдэг эд бараа зарцуулсан гэсэн үг. Энэ утгаараа Юнлэ хааны олон удаагийн түрэмгий аян дайн нь эргээд Мин улсын санхүүд томоохон дарамт учруулж байв. Тиймээс Юнлэ хаан хальсны дараагаас Мин улс түрэмгий гадаад бодлогоо хязгаарлаж, гадагш аян дайн хийхээс татгалзах болсноор цэргийн агт морьдын хэрэгцээ эрс багасжээ. Үүнийг ч сурвалжийн бичилт, тэмдэглэл давхар гэрчлэх бөгөөд “шилу тэмдэглэлд” жил бүрийн адууны тоог тогтвортой мэдээлж байснаа Юнлэгийн дараа үеэс дурдахаа больдог.

Өмнөх үеийн судалгааны үр дүн болж хэвлэгдэн нийтийн хүртээл болсон гадаадын судлаачдын өгүүлүүдийг харж байхад 1400-аад оноос өмнө Мин улсын зүгээс Монголчуудтай худалдаа хийсэн эсэхийг тэмдэглэсэн мэдээг бараг дурдаагүй санагдана. Гэхдээ сурвалжуудын ерөнхий төлөв үнэхээр тийм байдаг ч бидний олж харснаар бол худалдаа ор тас явагдаж байгаагүй гэж үзэх аргагүй ажээ. Жишээ нь 1374-аад онд Монголчууд хэд хэдэн удаа их бага хэмжээгээр адууг Мингийн албаны хүмүүст зарж байсан байна. Тийм боловч ийм тохиолдол үнэхээр цөөхөн байгаа нь нь Мин болон Монгол улсын хоорондын цэрэг улс төрийн харилцаа ихээхэн зөрчилтэй байсантай холбоотой нь мэдээж юм. Тиймээс Мин улс бусад газрын худалдаачдаар ялангуяа Төмөр, Зүүн Цагадай улсын худалдаачдаар дамжуулан Монголын адууг худалдан авч байсан байх гэж таамаглаж болох талтай.

Юнлэ хааны үеэс Монгол Мингийн хилийн худалдаанд “адууны зах” (馬市 *mashi*) гол үүрэг гүйцэтгэж эхэлжээ. Адууны зах нэртэй боловч төрөл бүрийн мал, малын бүтээгдэхүүн зардаг захууд байсан юм. Мин улс цэргийн зорилгоор адуу худалдан авах бодлого барьсан учраас “адууны зах” хэмээн нэрлэсэн. Тийм захуудыг Мин улстай хиллэсэн бүс нутаг, зүг чигээр ангилж авч үзэх боломжтой.

Ляодуны адууны зах. 1406 оны хаврын гурван сард “Ляодуны Кайюань, Гуаннинд адууны зах (馬市 *mashi*) байгуулсан”⁸³ хэмээн Мин улсын сударт өгүүлснээс үзвэл Урианхайн гурван харуул болон Зүрчидээс адуу худалдан авах “адууны зах”-ыг Кайюань болон Гуаннинд нээсэн нь тодорхой байна. Үүнээс өмнө Мин улс адууны зах нээж Урианхай болон Зүрчидээс агт морь худалдан

⁸¹ *Animals and Human Society in Asia* гэсэн эмхэтгэлд Ноа Грассын бичсэн зүйлийн 306-р талыг үзнэ үү.

⁸² Ноа Грассын хүснэгт (Дурдсан зохиол, р. 301 Table 10.1).

⁸³ 明史 (Mingshi), 卷六, 成祖二 (chengzu 2), 83 頁.

авч байсан эсэх нь тодорхойгүй. Магадгүй ордны худалдаа зонхилж байсан байж болох юм. Ляодуны адууны зах хамгийн тогтмол үйл ажиллагаа явуулж байжээ. Ляо голын зүүн этгээдэд Шэньян (одоогийн Мүгдэн)-ы хойд талд Цагаан хэрэм дотор байрлалтай Кайюань бол Ляодуны хязгаарыг хянахад стратегийн ихээхэн ач холбогдолтой байршил. Гуаннин нь Ляо голын баруун этгээдэд Зинжоугийн хойд талд цагаан хэрэмтэй ойр байрладаг мөн л стратегийн чухал байршил бөгөөд Ляодуны захирагч чухамхүү Гуаннинд суудаг байв. Энэ хоёр газарт адууны зах нээсэн нь бас давхар шалтгаантай болов уу. Яагаад гэвэл Урианхай, Зүрчидээс Мингийн нийслэлд ирэх элчийг дагалдан ирэх худалдаачдын авч ирэх адуу малын тоо хэт их болж ирсэн тул 1405 оны зуны дөрвөн сараас эхэлж малын бэлчээр ус сайтай Кайюань, Гуаннинд адууны зах нээжээ. Энэ нь өмнөх 1406 оны хаврын гурван сард зах нээсэн гэх баримттай зөрчилдөх ч Мин улсын магад хуульд 1405 оны билгийн тооллын дөрвөн сарын 17, 1406 оны билгийн тооллын гурван сарын 23-нд тус тус энэхүү хоёр зах дээр зүрчид болон урианхайчууд ирж худалдаалсан гэж тодорхой тэмдэглэсэн байдаг⁸⁴. 1412 оны 5 сард Гуаннины адууны захыг баруун хойш Туань уул руу нүүлгэжээ. Гэвч нүүдэлчид мөн л худалдааны суурин газарт дураараа нэвтрэх нь үргэлжилсэн хэвээр тул 1425 оны билгийн тооллын хоёр сард үүнийг нь хориглох Мингийн хааны зарлиг гарч байв. Мингийн хаанаас адууны захыг хаахаар Ляодуны адууны товчооны захирагчид явуулсан зарлигтаа, бүдүүлгүүд маш зальтай, олон удаа мэхэлсэн, тэдэнд амархан итгэж болохгүй хэмээн адууны захыг хаах болсон үндэслэлээ нүүдэлчдийн зан аальтай холбожээ. Улмаар “Хэрэв тэд үнэхээр морь зарахыг хүсэж байгаа бол тэд Юнлэ хааны үед баталсан дүрмийг дагаж, хот руу орохгүйгээр морины худалдаа хийх ёстой. Үнэ нь хууран мэхлэхгүйгээр хоёр талдаа шударга байх ёстой. Худалдаа хийсний дараа тэдгээрийг цаг алдалгүй [хот/захаас гаргаж] явуулах ёстой”⁸⁵ хэмээжээ. Мин улсын магад хуулийн 1430-аад онд холбогдох мэдээнд Кайюань, Гуаннины адууны захын тухай өгүүлж байгаагаас үзвэл адууны захыг дээрх хоёр газарт буцааж авчирсан байна. Хэдэн онд ингэж шийдсэнийг тогтоох боломж хомс. Түүнчлэн сурвалжид Ляодуны адууны гурван захын тухай гардаг, Кайюаньд адууны хоёр зах байсныг ингэж тэмдэглэжээ. Мөн сурвалжид, 1425 оны билгийн тооллын хоёр сард холбогдох нэг мэдээ бий. Тэнд, Ляодуны захирагчаас “Урианхайн гурван харуулын Татарууд морь зарах хүсэлтэй байгааг” дээш айлтгасанд, хариуд нь Мингийн хааны ордноос:

“Дайсан залилан мэхлэх байдал олонтоо гаргаж байсан тул гүнээ итгэх хэрэггүй. Гэхдээ шууд татгалзах аргагүй. Хэрэв морь зарах нь үнэн бол Юнлэ хааны үеийн журмыг баримталж, адууны захад арилжаа хийж, хот руу оруулж болохгүй. Үнийн хувьд хоёр тал тэнцвэртэй байж, хохирол гаргаж болохгүй”⁸⁶ гэсэн заавар буцааж өгчээ.

⁸⁴ Henry Serruys. *Trade Relations: The Horse fairs (1400-1600)*. 1975. p. 94.

⁸⁵ Henry Serruys. *Trade Relations: The Horse fairs (1400-1600)*. 1975. p. 96.

⁸⁶ 明實錄 (Ming shilu). 仁宗實錄 (Renzong shilu). Хунши-ийн тэргүүн оны 2 сарын цагаагчин үхэр өдөр.

Энэ мэдээ нь Мин улсаас адуу худалдан авах гол газар нь “адууны зах” байсныг харуулахын хамт адууны зах нь байнга ажиллахгүй, Мин улс л хүссэн үедээ, тэгэхдээ зөвхөн ордны зөвшөөрлөөр нээдэг байсныг харуулж байна.

Бусад адууны захыг бодвол Урианхайн гурван харуул, Зүрчидтэй хилийн худалдаа хийх Ляодуны адууны хоёр эсвэл гурван зах нь харьцангуй тогтвортой ажиллаж байсан боловч Гуаннины адууны зах 1449-1478 онд хаагдсан билээ. Урианхайн харуулууд 1459 оны өвлийн арван хоёр сард, 1475 оны намрын найман сард, 1476 оны өвлийн арван сард тус бүр Гуаннины адууны захыг дахин нээх хүсэлт тавьсан ч Мингийн хааны ордон зөвшөөрөөгүй юм. Харин 1478 онд Урианхайн гурван харуулын адууны захыг дахин нээх хүсэлтийг Мингийн хаан хүлээн авахаар болсон. Энэ талаар, Мин улсын судрын Урианхайн гурван харуулын шастирт:

“14-р онд (1478) зарлиг буулгаж, гурван харуулын адууны зах (馬市 *mashi*)-ыг сэргээв. Анхандаа, улсаас Ляодун (遼東 *liaodong*)-д адууны зах гурвыг байгуулсан бөгөөд, нэг нь Чэндун (城東 *chengdong*)-д, бас нэг нь Гуаннин (廣寧 *guangning*)-д [байв], бүгд гурван харуулыг хүлээн авах зорилготой. Жэнтуну онуудад, түүний аймаг олон удаа урвасан учир татан буулгасан (罷之 *bazhi*). ... Олон удаа өлсгөлөнд зовж, адууны захыг сэргээхийг дахин дахин гуйсан боловч зөвшөөрсөнгүй. Тэр цаг хүрээд, ... сайд Чэнь Юэ хуандид айлтгасанд, сая зөвшөөрөв”⁸⁷ гэж бичсэн байдаг.

Ляодуны хилийн адууны зах хэзээ хаагдсан нь тодорхой бус ч Жэнтун (正統 *zhengtong*, 1436-1450 он)-ы онуудад “олон удаа урвасан” гэж дурдсан нь 1449 оны Монгол-Мингийн дайнд Урианхайн гурван харуулынхан Монголын талд орж, мэдээлэл өгсөнтэй холбоотой. Хилийн адууны худалдааны түүхэнд гарсан хамгийн том зөрчил энэ бөгөөд хоёр талын худалдаанд зохицуулах боломжгүй өөр хурц зөрчил дахиж нэг их гараагүй ажээ. Гэхдээ энэ хоёр хилийн адууны захыг хаасан өөр нэг том шалтгаан байна гэж бид үзлээ. Юнлэ хаан Монгол улсыг олон удаа довтолж, түрэмгий аян дайн хийсэн нь Мин улсын санхүүг хоосруулсан бөгөөд түүнийг нас барсны дараа Мин улс хол аялж байлдах бодлогоос татгалзсан учраас цэргийн агтны хэрэгцээ огцом буурч, адууны зах ажиллуулах шаардлагагүй болсонтой холбоотой. Нөгөө талаар, Монголчуудын эсрэг худалдааны хориг арга арга хэмжээ авч, эдийн засгийн хувьд хавчин боох бодлогод Мин улс шилжиж, үүндээ Урианхайн гурван харуул, Зүрчидийг бас хамруулчихжээ. Ийнхүү Жэнтуну үед хаагдсан Ляодуны адууны захыг Урианхайн гурван харуулын Монголчууд удаа дараа хүсэлт тавьсаар байгаад 1478 онд дахин нээлгэж чаджээ. Гэвч энэхүү зах нээсэн нь бас Мингийн төрийн бодлогоос улбаатай үйлдэл болно. Учир Мин улс энэ үеэс эхэлж Монголын их хаан шууд захирдаг Монголчуудын эсрэг худалдааны хориг арга хэмжээг ид хэрэгжүүлж байсан ба Ляодуны “адууны захыг” харин дахин нээх нь Урианхайн гурван харуулын Монголчуудыг Мин улсын талд байлгах, арга ядахад тэднийг

⁸⁷ 明史 (Mingshi), 卷 328, 朵顏、福餘、泰寧. 8507 頁; Мин улсын судрын Урианхайн гурван харуулын шастир. Мин улсын судар. т. 232

бусад Монголчуудтай нэгдэхээс сэргийлэх гэсэн арга бодлоготой холбоотой хэмээн бид харж байна. Ер нь, Мин улсаас Ляодуны “адууны захын” талаар явуулсан бодлогыг Датун “адууны захын” бодлоготой харьцуулахад Кайюань, Гуаннины хоёр захын талаар Мингийн зүгээс харьцангуй уян хатан, зөөлөн бодлого баримталж байсан нь илэрхий харагддаг.

Ляодуны захиргаанд харьяалагдах энэ хоёр захын үйл ажиллагааны тогтмол хуваарь байсан эсэх нь төдийлөн тодорхойгүй байна. Сүүл үеийн 1478 оны баримтаар бол Гуаннины адууны захыг дахин нээсний дараа тус захыг сард хоёр удаа, харин Кайюаний адууны захыг сард нэг удаа ажиллуулдаг байсан байна. Тэгэхдээ Гуаннины зах сар бүрийн нэгнээс тавны хооронд эсвэл 16-наас – 20-ны хооронд, Кайюаний зах сар бүрийн нэгнээс таванд ажиллаж байжээ⁸⁸. Гэхдээ адууны захыг улиралд хэдэн удаа, хэдэн өдөр ажиллахыг хоёр талаас тохирдог байжээ. Тийм хэдий ч Мин улсын зүгээс худалдааны явцад гарсан аливаа зөрчлийг шалтаг болгон адууны захыг нээлгүй удах, эсвэл гэнэт үргэлжлүүлэн хаах гэсэн огцом шийдвэр байнга шахуу гаргаж зах дээр ирж адууд худалдах монгол, зүрчид хүмүүст шахалт дарамт үзүүлж байжээ.

Ляодуны адууны зах нь хойд хилийн адууны захууд дотроос хамгийн тогтвортой ажиллаж байсан хилийн худалдаа ба 1600-аад оноос хойш ч гэсэн үйл ажиллагаа үргэлжилсээр байсан зах юм.

Датуны адууны зах. Монгол-Мингийн худалдаанд Датун болон Сюаньфүгийн “адууны зах” чухал үүрэгтэй байсан. Датун, Сюаньфүгийн адууны захын талаарх тодорхой мэдээ Мин улсын магад хуульд харьцангуй бага тэмдэглэгдэж үлджээ. Ялангуяа, Сюаньфүгийн адууны захын талаарх мэдээ бараг л байхгүйтэй адил. Тиймээс Монголчуудаас Мин улстай худалдаалах гол зах болсон Датун адууны захаар хилийн худалдааг тоймлож, төлөөлүүлж авч үзье.

1438 оны дөрвөн сард Мингийн сайд “Ойрадын адуугаар алба барихаар илгээсэн элчийг [яха талаар хэлэлцэж байгаа билээ, миний санахад] Ляодуны жишгээр ... адууны зах байгуулж, албанд барих адууг сонгон авчирч, шууд уулзахыг хориглон, хэлмэрч сонгоод зуучийн газар байгуулья” хэмээсэн айлтгал өргөжээ. Гэтэл Мингийн хаан “адууны зах цэрэг ардыг ядраах тул байгуулах хэрэггүй. Холын хүмүүсийг өгөөмөр зузаанаар дайлах хэрэгтэй”⁸⁹ хэмээн Датунд адууны зах байгуулах гэсэн сайдынхаа саналыг хүлээж аваагүй аж. Харин элч худалдаачдыг өгөөмөр дайлж, албанд барих адууг авчруулж улсын сангаас төлбөрийг төлөхөөр шийдсэнээ дуулгажээ. Дашрамд өгүүлэхэд энэ баримтанд буй элч илгээн “алба барив” гэсэн мэдээ нь элчин/ордны худалдааны хэлбэр байсныг маш тодорхой харуулж байна.

Гэвч хэд хоногийн дараа Мингийн хаан:

“Датунд адууны зах байгуулж, холын хүмүүсийн авчирсан тэмээ морийг цэрэг ардууд үнэлж худалдан авах нь зүйтэй. Их түшмэл ... илгээж тэдний үг

⁸⁸ Henry Serruys. *Trade Relations: The Horse fairs (1400-1600)*. 1975. p. 126.

⁸⁹ 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жэнтуну 3-р оны 4 сарын улаагчин үхэр өдөр.

яриаг хэлмэрчилж, цэргийн зэвсэг болон хүрэл, төмөр эд арилжаалахыг хатуу хориглогтун”⁹⁰

гэсэн зарлиг буулгасан нь 1438 оны дөрвөн сарын харагчин хонь өдөр бөгөөд Мин улсын магад хуульд тэмдэглэснээр бол зарлигийг ёсоор болгосон гэдэг. Мингийн хааны зарлигаас үзвэл, Датуны адууны захыг Монголын элч нарын авч ирсэн адуу малыг албаны болон хувь хүмүүс худалдан авах зорилгоор нээжээ. Тийм боловч Датуны адууны зах нь улирал юм уу, сард тогтоосон тогтмол хугацаагаар ажилладаггүй, зөвхөн Монголын элч адуу мал авч ирсэн үед нээгдэж ажилладаг зах байсан юм. Өөрөөр хэлбэл, монголчуудын “алба” барьсан адууны шилдгийг нь Бээжинд ордны хэрэгцээнд авч явах ба үлдсэн адуу малыг Датуны цэргийн хэрэгцээнд худалдан авах бөгөөд үүний дараа сая үлдсэнийг албан газар болон хувь хүмүүст худалддаг байжээ. Жишээлбэл, 1439 оны билгийн тооллын арван сард Тогтобуха хаан Адучи тэргүүтэй мянга гаруй элчийг Мин улсад илгээж 3725 морь, 13 тэмээ, 3400 булганы арьс болон өөр бусад эд зүйлээр “алба барьжээ”. Тэгэхэд нь элч нарын авчирсан адуу мал олон тул хуучин журмаар өвс тэжээл олгоход хүндрэлтэй байна, иймээс тэжээлийг хасаж талыг нь олгоё хэмээн айлтгахад Мингийн хаан “хуучин журмаар өгөгтүн” хэмээн хариулж байжээ⁹¹.

Хэдийгээр энэ үеийн хилийн худалдааны талаарх илүү нарийн мэдээ Мин улсын магад хууль зэрэг сурвалжид ховор харагддаг ч Тогтобуха хаан, Эсэн тайши хоёрын илгээсэн элчийн багийн жишээг харгалзан үзэж болох байх. Хэдэн мянган хүний бүрэлдэхүүнтэй хаан, тайши хоёрын илгээсэн элчийн баг нь 40 мянгаас илүү тооны адуу мал тууж ирж байжээ. Датуны “адуюны зах” дээр ихэнхийг нь худалдаалсан болов уу. Ингэхлээр Датуны адууны захад өрнөдөг худалдаа нь Монголын талын элчтэй шууд хамааралтай байсан гэсэн үг. Тийм ч учраас Монгол, Мин хоёр элчийн тал дээр тоонд, дагагч хүмүүсийн их багад, улмаар авчрах адуу малын тоо толгойн талаар байнга хоорондоо зөрчилдөж тохиролцож чаддаггүй байжээ. Монголын элчийн тоо нэмэгдэж, адуу мал олшрохын хэрээр Мин улсаас гаргадаг зардал сүйтгэл эрс нэмэгдэж эхэлсэн учир Мингийн хаан элч нарынхаа тоог цөөлөхийг шаардсан шаардлагыг Монголын талд удаа дараа тавьж байв. Гэтэл Монголын тал харин ч эсрэгээр элчийн тоогоо нэмэхийн хамт Мингийн хаан бас элч зарж байхыг шаардаж байжээ. Тухайлбал, Тогтобуха хаан, Эсэн тайши хоёр элчийнхээ тоог цөөл гэсэн Мингийн хааны шаардлагыг хүлээж авалгүй, хариу элч зарж Мингийн эрх баригч нарт “Жэнтун (Zhengtong, 1436-1449 он)-ы үетэй адил элч томилж харилцахыг хүсмүй” гэсэн шаардлага хүргүүлжээ. Гэтэл Мин улсын хаан элчээ Монгол улс руу илгээхээс бүрэн татгалзсан бодлого барьж эхэлсэн байна. Ийнхүү, нэг талаас элч, худалдаагчид, тэдний хил дээр авч ирэх адуу малын тоог нэмэгдүүлж, өргөн хэмжээнд худалдаа хийх гэсэн Монголчуудын оролдлого, нөгөө талаас элч нар,

⁹⁰ 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жэнтуну 3-р оны 4 сарын харагчин хонь өдөр.

⁹¹ 明實錄 (Ming shilu). 英宗實錄 (Yingzong shilu). Жэнтуну 3-р оны 10 сарын улаагчин гахай өдөр.

тэдний авч ирэх малын тоог хязгаарлах гэсэн Мин улсын бодлогын зөрөлдөөн яваандаа зөрчил тэмцэл гарахад хүргэсэн юм.

1454 оноос хойш Монголчуудтай хилийн худалдаа хийсэн тухай мэдээ хятад сурвалжид харагдахаа больдог. Мин улс хилийн худалдааг хааж, Монголчуудын эсрэг худалдааны хориг тавих бодлогоо тууштай хэрэгжүүлж эхэлсэн үе юм. Чухам, улс төрийн хувьд Монголыг тусгаарлах зорилгоо, худалдааны хориг тавих бодлоготой хослуулан хэрэглэх тактикт шилжиж эхэлсэн хэрэг. Ингэснээр 1454 оноос 1571 он хүртэл Монгол-Мингийн худалдааны харилцаа хязгаарлагдаж, зарим үед бүрэн тасалдаж, харилцаа зогсдог байжээ. Улс төрийн дээд түвшинд ч тэр харилцаа тогтмол бус болж, хоёр харилцан элч илгээх бас зогсоодог тохиолдол ч олон гарах болжээ. Элчин харилцааны энэхүү тогтмол бус байдал Датун, Сюаньфүгийн адууны захын үйл ажиллагаа хязгаарлагдахад хүргэсэн нь тодорхой.

Мин улсаас Дотоод Азийн бусад улс орнуудтай харилцаж байсан худалдааны бодлогыг Монгол улстай хийх худалдаанд баримталж байсан бодлоготой харьцуулах замаар Мингийн зүгээс цэрэг, улс төрийн талаар Монгол улсыг дайсагнасан бодлого баримталж, эдийн засаг, худалдааны талаар хавчин хориглох бодлогоор түүнийгээ дэмжиж, хүчжүүлэхийн оролдож байсныг тодруулж болно. Мөн, хилийн боомт Датун захыг их цөөхөн удаа⁹² нээгээд удалгүй хааж байсан баримт нь Мингийн түрэмгий бодлогын бас нэг илрэл болох юм.

Гэхдээ Мингийн бодлого тэр бүр амжилт олдоггүй байсан юм. Ялангуяа Дотоод (Төв) Ази бараг тэр чигтээ Монголын их хааны мэдэл шууд харьяалагдаж, хүчтэй нэгдэл нь бүр хүчжих үед Мингийн төрийн бодлогоо хэрэгжүүлэх гэсэн оролдлого ахих нь байтугай бүр зогсонги байдалд шилждэг ажээ. Хүчирхэг хаадын⁹³ бодлогоор харин Монголчууд нэг мэт хөдөлж Мингийн худалдааны хориг зэргийг тууштай эсэргүүцэж, сөрж арга хэмжээ авдаг юм. Тухайлбал, Батмөнх даян хаан Монголчуудыг нэгтгэн захирч хүчирхэгжиж, Мин улсад элч илгээн харилцсан ч хүлээн аваагүй тул хил хязгаарыг зориуд түйвээх тактикт шилжсэн байна. Аргагүйдсэн Мин улс нь Хунжи-гийн тэргүүн он буюу 1488 оны зургаан сард ирсэн Батмөнх даян хааны элчийг хүлээн авсан байдаг. Мин улсын магад хуульд Батмөнх даян хааны илгээсэн 1,539 элч, 4,930 адуу тэмээг худалдаалахаар тууж ирснийг Датун адууны захын ойролцоо байрлуулсан⁹⁴ гэж тэмдэглэсэнээс үзэхэд монголчууд адуу малаа Датун адууны захад худалджээ.

1490 оны билгийн тооллын хоёр сард холбогдох Мин улсын магад хуулийн нэгэн мэдээнд, урьд хааны зарлигаар “умардаас 1,100 хүнийг боомтоор нэвтрүүлж, 400 хүнээр алба бариулахаар тогтсон. Ойрадаас 400 хүнийг боомтоор

⁹² Зарим баримтаар 1338, 1454, 1498-1499 онд маш богино хугацаагаар нээж байсан гэдэг.

⁹³ 1368 онд эх нутагтаа эргэж ирсэн хаадын бодлого, үйл ажиллагаа нь Мингийн эрх баригч нарт үл таалагдаж байсан л учраас тэд нар өөрсдийн түүх судартаа Монголын хаадыг доромж хоч нэрээр нэрлэж “бага хаан/бага хаад” гэж бичиж үлдээжээ. Монголын түүх бичлэгт гадны дэмжлэгээр суурьшихаад байгаа олон нэр томьёоны нэг нь энэхүү бага хаад гэсэн ойлголт юм.

⁹⁴ 明實錄 (Ming shilu). 孝宗實錄 (Xiaozong shilu). Хунжигийн тэргүүн оны 5 сарын хөхөгчин тахиа өдөр; Хунжигийн тэргүүн оны 6 сарын хөхөгчин тахиа өдөр

нэвтрүүлж, 150 хүнээр алба бариулахаар тогтсон”⁹⁵ гэж дурддаг. Дээрх мэдээ нь XV зууны сүүл үеийн Монгол-Мингийн элчин худалдааны ерөнхий төлөв байдлыг харуулахын хамт, Датуны адууны зах дээр Монголчууд адуу мал авчирч зарж байсныг дам гэрчлэх баримт болох юм.

Харин энэхүү журмыг Монголчууд үл тоон, элч явуулах болсныг 1496 оны билгийн тооллын таван сард Батмөнх даян хаан 3,000 хүнтэй элчийн том баг, 1504 оны билгийн тооллын гурван сард бүр 6 мянган хүний бүрэлдэхүүнтэй элчийн баг илгээж байснаас харж болно. Тэгэхэд нь Мингийн хааны ордон 1490 оны журмаа орхиход хүрч оронд нь олон жилийн жишиг дагах болж “зарлигаар 2,000 хүнээр алба бариулахыг” зөвшөөрч байжээ⁹⁶. Бээжин орж “алба барих” зөвшөөрлийн тоонд багтаагүй үлдсэн элч нарыг адуу малаа Датуны адууны зах дээр борлуулахыг зөвшөөрсөн бололтой. Харамсалтай нь Мин улсын магад хуульд энэ үеийн Датуны адууны захын талаар дурдаагүй орхижээ. Энэ нь, хилийн адууны захын үйл ажиллагаанд Мингийн хааны ордноос тавьдаг хяналт суларч, ач холбогдол багассантай, мөн хилийн худалдааны энэ төрлийг тухай тухайн хилийн муж нь хариуцаж эхэлсэн учраас нийслэлд байрладаг төрийн баримт бичигт тэмдэглэгдэхээ больсонтой холбоотой бололтой.

Алаг цоог байдалтай явж ирсэн хоёр улсын улс төр-худалдааны давхар харилцаа нь 1530-аад оноос Мин улсын хааны ордноос баримталж эхэлсэн бодлогоос шалтгаалж бүрэн зогсох болов. Монголчуудын “алба барих” болон худалдааны харилцааг бүрэн зогсоон, хилийн худалдаанд хориг тавьсан Мингийн төр, бүр бага зэргийн худалдаа хийх шаардлагаас ч татгалзах⁹⁷ бодлогыг тууштай баримталжээ. Жиажинны үеийн (1522-1567 он) Монгол-Мингийн харилцааг судалсан К.Т.Фишер, 1530-аад оноос хоёр талын солилцоог хориглосон тул монголчууд Мингийн хил хязгаарт байнга халдан довтлох болсон. Мингийн хааны ордон хилийн худалдааг нээх, эсвэл Монголчуудын цэргийн хүчтэй нүүр тулах хоёр сонголттой тулгарсан⁹⁸ гэсэн нь Мин улсын хил хязгаарт халдах Монголчуудын довтолгооны шалтгаан бол яах аргагүй Мингийн хааны ордны баримталдаг худалдааны хоригтой холбоотой гэдгийг хүлээн зөвшөөрсөн дүгнэлт болжээ.

ДҮГНЭЛТ

Монгол-Мингийн худалдааны харилцаа бол Мин улс Монголыг шууд түрэмгийлэх бодлогоос хараат улс болгох бодлогод, улмаар хоёр улсын харилцааг тусгаарлаж, худалдааны хориг тавих бодлогод шилжсэний шууд тусгал болж

⁹⁵ 明實錄 (Ming shilu). 孝宗實錄 (Xiaozong shilu). Хунжигийн 3-р оны 2 сарын харагчин могой өдөр

⁹⁶ 明實錄 (Ming shilu). 孝宗實錄 (Xiaozong shilu). Хунжигийн 9-р оны 5 сарын хөхөгчин хонь өдөр; Хунжигийн 17-р оны 3 сарын хар морь өдөр

⁹⁷ Serruys, H. *Trade Relations: The Horse fairs (1400-1600)*. Institute Bilge des Hautes Etudes Chinoises, 1975. p. 149.

⁹⁸ Carney T. Fisher. Smallpox, Salesmen, and Sectarians: Ming-Mongol Relation in the Jiajing Reign (1522-67). *Ming Studies*, 1988:1, p. 1.

чаддаг хоёр улсын харилцааны нэг чухал бүрдүүлэгч бөгөөд мөн Монгол-Мингийн харилцааг үечилж, үе шатад хуваах үндэс болно.

Мин улс эхэн үедээ Монголчуудыг Мингээс хараат байдлаа хүлээн зөвшөөрөхийг шаардаж, түрэмгий бодлого явуулсан бол, Монголчууд нь түүнийг хүлээн зөвшөөрөхгүй Мингийн бодлогыг эсэргүүцэж, Мин улстай эрх тэгш харилцахыг шаардсан бодлого баримталж байсан ба ийм нөхцөлд Монгол-Мин хоорондоо худалдааны харилцаа хөгжих боломж бүрэлдээгүй ажээ.

Харин Юнлэ хааны идэвхтэй гадаад бодлогын явцад Монгол-Мингийн худалдааны харилцаа аажмаар үүсэн хөгжиж, “ордны” (элчин) болон “хилийн” гэсэн худалдааны хоёр хэлбэр бүрэлдэн тогтов. Мин улс цэргийн агтаар ихээхэн гачигдаж байсан тул “адууны зах” байгуулж, агт морьдыг торго, цайгаар солих хилийн худалдааг идэвхжүүлжээ. Монголчууд Мин улсад адуугаа гол төлөв торгоор худалдаалдаг байсан бол Түвэдүүд болон Төмөрийн улсын худалдаачид цайгаар адуугаа арилждаг байжээ. Мин улсын хувьд ч гэсэн гадаад худалдааных нь идэвхтэй үе байсан юм.

Юнлэ хааны дараа үеэс Мин улс гадагшаа түрэмгий аян дайн хийхээс татгалзсанаар цэргийн агтны хэрэгцээ багасаж үүнтэй холбоотойгоор Мин улсаас Дотоод Азийн улс орнуудтай худалдаалах гадаад худалдаагаа хязгаарлаж эхэлжээ. Ялангуяа, монголчуудын эсрэг худалдааны хориг тавьж, хүч чадлыг нь бууруулах бодлогыг Мин улс баримтлах болов.

Харин Монголыг нэгтгэн захирсан Тогтобуха хаан болон ойрадын Эсэн тайши хоёр нэгдмэл бодлогоор Мин улстай харилцаж, тогтмол худалдаалж байхыг Мин улсаар хүлээн зөвшөөрүүлж чадсан ч Монгол-Мингийн 1449 оны дайн, ялангуяа Түмү-д болсон тулалдаанаар Мингийн хааныг олзолсон явдал Мин улсын гадаад бодлогод томоохон нөлөө үзүүлжээ. Энэхүү гутамшигт ялагдлынхаа дараа Мин улсын шинэ хаан Монгол улсыг улс төрийн хувьд тусгаарлах, зэрэгцээд худалдааны хориг тавих бодлогод шилжсэн ч Чэнхуа (chenghua)-гийн үед (1465-1487 он) зөвхөн энэ бодлогыг Мингийн төр баримталж тууштай хэрэгжүүлсэн юм. Мин улсаас Монголд элч илгээхээ зогсоож, зөвхөн Монголын талаас элч илгээдэг болжээ. Ийнхүү Мин улсын Монголын эсрэг явуулсан хориг арга хэмжээний улмаас элчин худалдаа хязгаарлагдсан бол хилийн худалдаа үндсэндээ тасалдсан юм.

Мин улсын худалдааны хоригийн бодлогыг Монголчууд эсэргүүцэхдээ Мингийн хил хязгаарыг уулгалан довтлох стратеги-тактик баримталснаар хоёр улсын харилцаа бүр ч хурцадсан. Монголчуудын хилийн уулгалалт довтолгооны үндсэн шаардлага нь хилийн худалдааг нээх явдал байсаар иржээ. Монгол-Мингийн худалдааны харилцаанд шууд тусгалаа олсон Мин улсын баримталсан бодлогоос үүсэлтэй харилцааны ийм төлөв байдал 1571 онд Алтан хан-Мин улстай гэрээ байгуулах хүртэл 120 орчим жил үргэлжилсэн билээ.

Дээр дурдсанаа нэгтгэж, товчхон өгүүлбэл – Монгол-Мингийн худалдааны харилцааг дараах үеүдэд хуваах боломжтой боллоо. Үүнд,

1. *Монгол-Мингийн шууд бус худалдааны үе. (1368-1402 он).*

Энэ үед Мин улс лалын худалдаачдаар дамжуулж, эсвэл тодорхой нутагт элч илгээж монголчуудаас агт морьд худалдан авах бодлого хэрэгжүүлжээ.

2. *“Ордны” болон “хилийн” худалдаа хөгжсөн үе (1403-1450 он).*

Монгол-Мингийн хооронд “ордны” болон “хилийн” худалдаа хөгжиж, худалдааны дээрх хоёр хэлбэр бүрэлдэн тогтов.

3. *Мин улсын зүгээс тавьсан худалдааны хоригийн үе (1450-иад оноос – 1570 он).*

1450-иад оноос Мин улсаас Монголд худалдааны хориг тавих бодлого баримталж, хууль ёсны худалдааг хязгаарласан нь Мингийн талд эсрэгээр нөлөөлж хил орчмын далд худалдаа дэлгэрэх үндэс тавигдаж, даруй цэцэглэн хөгжжээ. Мин улсын худалдааны хоригийн эсрэг монголчууд хилийн уулгалалт довтолгооны стратеги-тактик баримталснаас гадна хилийн далд худалдааг хөхүүлэн дэмжсэн байна.

4. *Монгол-Мингийн худалдааны харилцаа сэргэсэн үе (1571-ээс XVII зууны эхэн хүртэл).*

1571 онд Алтан хан-Мин улстай гэрээ байгуулснаар Баруун гурван түмэн болон Мин улсын хооронд Мингийн төрийн давуу эрх ноёлсон хилийн худалдаа тогтмолжжээ. Гэхдээ онцлог бий, үүнд, Түмэдийн Алтан ханаас худалдааны тал дээр авч хэрэгжүүлсэн бодлого нь Монголын хаадын баримталж байсан нэгдмэл бодлогоор Мин улстай худалдаалах эртний зарчим, бодлогыг үндсэндээ эвдсэн бөгөөд, ингэснээр түүний Мин улстай байгуулсан гэрээ нь бараг худалдааны салангид гэрээний шинжтэйд оршино.

Монгол-Мингийн худалдааны харилцааны үечлэл нь ийнхүү Мин улсын баримталсан бодлого, түүнд хариу үзүүлэх Монголын бодлогоос шууд хамааралтайгаар үечилж тогтоогдох ч дараах онцлогуудтай билээ.

Монгол-Мингийн харилцаа нь XVII зууны эхэн үе хүртэл Монгол-Хятадын уламжлалт хоёр талт харилцааны зарчимд суурилж хөгжиж байв. Харин Лигдэн хааны үеэс энэхүү харилцаанд бас оролцогч нэмэгдэж улмаар Монгол-Мин-Манжийн гурван талт харилцаа бий болсноор бүс нутгийн олон улсын харилцааны түүхэнд цоо шинэ үе эхэлсэн юм.

Мин улс гадаад худалдаандаа төрийн монополь тогтоож, гадаад харилцааны нэг чухал бүрдүүлэгч хэрэгсэл болгож худалдааг ашигладаг учир Монгол-Мингийн худалдаа нь юуны өмнө Мин улсын хааны ордны бодлогоос шууд хамаарч өөрчлөгдөж байсныг цохон тэмдэглэе.

Түүнчлэн, зөвхөн Дотоод Азийн ард түмнүүд л суурин иргэншлийн бараа таваараар ямагт гачигдаж, Мин улстай л худалдаа хийх сонирхолтой байсан гэх үзэл нь учир дутагдалтай юм. Мингийн арми Хань, Тангийн үе шиг гадагшаа түрэмгий аян дайн их хийж байсан бөгөөд хол аялж байлдах бүрт нь цэргийн агтны хангамжийн асуудал хурцаар тавигддаг байжээ. Иймээс адуу ихтэй Монголоос цэргийн агт морьд худалдан авах сонирхолтой байсан боловч Хун-у хааны үед хааныхаа баримталж бодлогоос шалтгаалж Монголыг тойрсон

улс орнуудаас агт морьд их хэмжээгээр худалдан авахыг удаа дараа оролджээ. Гэвч тухайн бүс нутгийн адууны нөөц тэр болгон хүссэн үр дүнд хүргээгүй юм. Тиймээс Юнлэ хааны үеэс хилийн худалдааг “адууны зах” хэмээн нээж, агт морьдыг их хэмжээгээр худалдан авч эхэлсэн нь түүний намтар түүхэнд тэмдэглэгдэж үлдсэн билээ.

Мин улсын хааны ордон Монголчуудтай хийх худалдааг хатуу хянаж, зэр эвсэг, төмөрлөг эдлэл, торго, цайг хил давуулж, далдуур худалдахыг хатуу хориглож байжээ. Жишээ болгож төвөөс албаны хүмүүс Шэньси мужид томилогдож, тодорхой хугацаанд ажиллаж хатуу хяналт үйлдэж байсан баримтыг дурдсан. Монголоос тууж аваачсан түм илүү адуу ганцхан өдрийн дотор зарагдаж дуусдаг түүхэн баримтаас үзэхэд Мингийн тариачид нь үхрээс гадна адууг газар хагалахад зүтгэх хүч болгон ашиглах нэн сонирхолтой байсан байна. Иймээс тариачид жирийн иргэд Мингийн хууль цаазыг зөрчин байж, хилийн далд худалдаагаар ч болов агт морь худалдан авахыг их чухалчилж байжээ. Харин Монголчууд торго, даавуу, будаа, тариа, төмөрлөг эдлэл авах сонирхолтой байсан нь арай хожмын баримтаар гэрчлэгдэнэ. Хоёр талын худалдааны энэхүү сонирхол дээр тулгуурласан худалдааны хэлбэрээс “адуу-торгоны” худалдааны хэлбэр хамгийн их хөгжжээ. Мин улсаас худалдааны хориг тавьсан жилүүдэд Монгол-Мингийн хилийн нууц худалдаа өргөжин хөгжиж байсан нь монгол, хятад иргэд хилийн худалдаа хийх адилхан шаардлага, сонирхолтой байсныг тодорхой харуулж байна.

Монгол-Мингийн худалдааны харилцааны түүхийн судалгаанд одоо болтол буруу ойлгож тайлбарласаар ирсэн нэг чиглэл байдаг нь баян чинээлэг Хятад орныг байнга уулгалан дээрэмдэж байж сая санаа нь амардаг нүүдэлчдийн тухай “үлгэр” юм. Өөрөөр хэлбэл, ихэнх судлаачид Монголчуудын хилийн уулгалалт довтолгоог зөвхөн булаан дээрэмдэх шинжтэй гэж нэг л талаас нь, нэг өнцгөөс харж тайлбарлах явдал үргэлжилсээр байна. Гэтэл Монгол-Мингийн худалдааны түүхээс харахад *худалдааны хориг – уулгалалт довтолгоо* гэсэн хоёр тэс өөр үзэгдэл нь хоорондоо салшгүй холбоотой үйл ажиллагаа байсан ба Монгол-Мингийн харилцааг тодорхойлогч гол нөхцөл, хүчин зүйл байжээ. Тиймээс нэг талаас Мингийн худалдааны хориг тавих бодлого, нөгөө талаас худалдааны хориг тавих бодлогын эсрэг Монголчуудын авч хэрэгжүүлдэг бодлого буюу хилийн уулгалалт довтолгооны стратеги-тактик нь Монгол-Мингийн худалдааны харилцааны хувьсал/хувирал, өөрчлөлтийн шалтгаан болж байв.

Монголчуудын хувьд Монгол-Мингийн худалдааны харилцаанд дараах хэдэн бодлого баримталж байсан гэж үзэж болохоор боллоо. Үүнд, Мин улстай харилцах, худалдаалахын тулд Монголчууд Мингийн хил хязгаарыг бага хүчээр байнга шахуу уулгалан довтолж шахамдуулахаас гадна хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд, Мингийн цэргийн аялан байлдах чадварын үндэс болсон цэргийн агт морьдын хангамжийг тасалдуулахын тулд Хөх нуурын чиглэлд удаа дараалан довтолж тус газрыг эзлэн суурьшсанаар Түвэд-Мингийн хооронд явагдаж байсан “цай-адуу” гэсэн худалдааны сүлжээ, жигд ажиллагааг

нь тодорхой хэмжээнд тасалж чаджээ. Улмаар Түвэдүүдээс агт морь худалдаалах пайз тэмдгийг нь хүртэл авч түүнийг барьж Мингийн түшмэлүүдтэй худалдаалж байжээ. Юнлэ хааны довтолгооны дараа цохилтонд өртсөн Аругтай зүүн зүгт анхаарч, Урианхай монголчуудыг довтолсноор Мин улсаас зүүн хойд зүгт дэлгэсэн адууны хангамжийн судлыг таслах эхлэл тавьжээ. Тогтобуха хааны үед уг бодлогыг үргэлжлүүлж Мин улс Гуаннины адууны захыг хаах замаар буюу худалдааны хориг тавих бодлогоор Монголын түрэлтийг зогсоохыг оролджээ. Энэ нь алс хэтдээ үргэлж тэдний бодлого, эрхшээлд явж ирсэн зүрчид нарыг хүчирхэгжихэд нөлөөлсөн томоохон хүчин зүйл болжээ. Урианхай монголчууд адуугаа зарахын тулд зүрчид нарт зориулсан адууны захыг ашиглаж эхэлсэн нь тэд нар аажимдаа нэгдэж хамтрахад хүргэв.

Хань улс, Баруун Жинь улс, Тангийн төрөөс адууны үйлдвэрлэлийн гол бүс нутаг болгож ашиглахын тулд нүүдэлчдээс булааж авсан Ордост Монголчууд XV зууны 60-70-аад онд ноёрхлоо тогтоож, Дотоод Азийнхны орон зайд буцаасан нь улс төрөөс гадна эдийн засгийн ашиг сонирхлоос үүдэлтэй бодлого дагуух үйл явдал байсан бололтой. Газар нутаг олохын тулд утга учиргүй довтолж эзэлсэн явдал биш болох нь Монгол-Мингийн худалдааны чухал үндэс болсон адууны худалдааны түүхийн судалгаанаас илэрч байна. Мингийн төрөөс худалдааны хатуу хориг тавих бодлого хэрэгжүүлж эхлэхэд Монголчууд тус улсын баруун хойд, зүүн хойд хил дээрээ нээсэн адууны захуудыг ажиллагаагүй болгох, улмаар тэдгээр захад адуу зардаг бүс нутгийг эзэлж авах арга бодлогоор хариу барьжээ.

Монгол – Мингийн худалдааны түүхээс харахад, худалдааны хориг - уулгалалт довтолгоо нь хоорондоо салшгүй холбоотой байж, Монгол – Мингийн харилцааг тодорхойлогч зүйл болсон ажээ. Тиймээс нэг талаас Мингийн худалдааны хориг тавих бодлого, нөгөө талаас худалдааны хоригийн эсрэг Монголчуудын хилийн уулгалалт довтолгоо хийх стратеги-тактик нь Монгол Мингийн худалдааны харилцааны хувирал, өөрчлөлтийн шалтгаан болж байв.

Эцэст нь тэмдэглэхэд, алба өргөж, вассал хараат байдлаа хүлээн зөвшөөрвөл худалдаа хийх зөвшөөрөл олгодог Мин улсын бодлого бусад улсын хувьд тун амжилттай хэрэгжсэн боловч, Монголчуудыг хувьд төдийлөн амжилтад хүрээгүй бөгөөд Мингийн худалдааны хориг тавих, эдийн засгийн хувьд боож хаах бодлогод авталгүй монголчууд тэсэж үлдсэн гэсэн дүгнэлт хийж болно. Тэгэхээр Монгол, Мин нь үнэхээр үл зохицох эсрэг тэсрэг зарчим баримталсаар бүс нутгийн олон улсын харилцааны шинэ үетэй золгосон ажээ.

Abstract

The changes in the politics and foreign policy of the two countries at that time determined the trade relations between Mongolia and Ming. The changes in the foreign policy of the Ming Dynasty were directly reflected in the trade relations between Mongolia and Ming, which was due to the fact that the Ming imperial court had a monopoly on foreign trade. The Ming Dynasty's foreign policy towards

Mongolia changed from a policy of direct aggression against Mongolia to a policy of making Mongolia a dependent state, and then to a policy of isolating relations and imposing economic sanctions, which directly affected the trade relations between the two countries. The Ming Dynasty used foreign trade as a means of exerting political pressure, using methods such as limiting the volume of trade, not selling certain goods, and closing border trade. In response, the Mongols used the tactic of raiding the Ming borders and exerting pressure. However, in reality, the Mongols' border incursions were against the Ming trade embargo and demanding the opening of border trade. Judging from the history of Mongol-Ming trade, trade embargo and incursions were inextricably linked and became a defining feature of Mongol-Ming relations.

Mongol-Ming trade relations can be divided into the following periods. These include:

1. The period of indirect Mongol-Ming trade. (1368-1402).
2. The period of development of "court" and "border" trade (1403-1450).
3. The period of trade ban imposed by the Ming Dynasty (1450s - 1570).
4. The period of revival of Mongol-Ming trade relations (1571 to the beginning of the 17th century).

This article examines the main factors that influenced Mongol-Ming trade relations until 1571 and the evolution of relations.